

## Ranking of Mongolian economists and economic institutions

Bataa, Erdenebat

### Economics: Theory and Practice

Published: 01/01/2020

Publisher's PDF, also known as Version of record

[Cyswllt i'r cyhoeddiad / Link to publication](#)

*Dyfyniad o'r fersiwn a gyhoeddwyd / Citation for published version (APA):*

Bataa, E. (2020). Ranking of Mongolian economists and economic institutions. *Economics: Theory and Practice*, 34, 2-35.

#### Hawliau Cyffredinol / General rights

Copyright and moral rights for the publications made accessible in the public portal are retained by the authors and/or other copyright owners and it is a condition of accessing publications that users recognise and abide by the legal requirements associated with these rights.

- Users may download and print one copy of any publication from the public portal for the purpose of private study or research.
- You may not further distribute the material or use it for any profit-making activity or commercial gain
- You may freely distribute the URL identifying the publication in the public portal ?

#### Take down policy

If you believe that this document breaches copyright please contact us providing details, and we will remove access to the work immediately and investigate your claim.

# Монгол эдийн засагчид, эдийн засгийн байгууллагуудын чансаа

Батаагийн Эрдэнэбат

Монгол Улсын их сургууль

*Редакцид ирүүлсэн: 2020.09.28; Засаж ирүүлсэн: 2020.11.06; Хэвлэхийг зөвшөөрсөн: 2020.11.07*

**Абстракт:** Орчин үеийн эдийн засгийн шинжлэх ухааны салбарт бид хаана байна, цаашид хөгжин дэвшихэд ямар урамшуулал, шаардлага хэрэгтэй байна вэ гэсэн асуултуудад хариулахын тулд олон улсад өргөн хэрэглэгддэг аргачлалаар монгол эдийн засагчид болон эдийн засгийн боловсрол, судалгааны байгууллагуудын чансааг тогтоов. Судалгаанд хамрагдсан 751 эдийн засагчийн 8.6%, 530 эдийн засгийн докторын 6.6% нь, БШУЯ-аас эдийн засгийн бакалавр болон түүнээс дээш зэрэг олгох зөвшөөрөл авсан 34 их, дээд сургуулиас 3 нь л олон улсад хүлээн зөвшөөрөгддөг *Web of Science*, *Scopus*-ын оноотой сэтгүүлд бүтээлээ нийтлүүлжээ. ЗХУ болон ОХУ-ын докторын дээд зэрэг болох *Доктор экономических наук*-тай 37 монгол хүнээс ганц нь ч, эдийн засгийн профессор цолтонгууд, дотоодын дээд зэрэг болох шинжлэх ухааны доктор (*ScD*) 18 хүн, эдийн засгийн салбараарх Монгол Улсын ШУА-ийн 7 академичаас ганцаас бусад нь, эдийн засгийн 23 профессороос 2-оос бусад нь, 41 дэд профессороос 4-өөс бусад нь тийм сэтгүүлд нийтлүүтээлгүй байгаа нь эдийн засгийн доктор, докторын удирдагч, доктор хамгаалуулах зөвлөлийн гишүүн, профессор, академичид тавигдах шаардлагыг өндөрсгөх цаг болсныг харуулж байна. Энэхүү судалгааны ажлын өгөгдөл, дуурайлган гүйцэтгэх компьютерийн *R* кодыг олон нийтэд нээлттэй хуваалцаж байгаа бөгөөд бусад салбарынхан үүнийг мөн ашиглаж үзэхийг уриалъя.

**Түлхүүр үгс:** Академик эдийн засагч, Шинжлэх ухааны хөгжил, Чансаа, Монгол;

**JEL код:** A1,H83,I23.

---

Эдийн засгийн тэнхим, Хичээлийн 5-р байр 603 тоот, Улаанбаатар, Монгол. Утас: +976-95343365, имейл: tsors79@yahoo.com;

Талархал: Энэхүү ажлын өмнөх хувилбарт зөвлөгөө өгсөн МУИС-ийн Эдийн засгийн тэнхимийн семинар болон Монголын Эдийн засгийн холбооны хуралд оролцогчдод, шүүмж өгсөн сэтгүүлийн редакторууд болох Н. Ууганбаатар, Д. Ган-Очир, Ц. Гэрэлт нарт гүнээ талархаж байна. Гэвч орхигдуулсан болон ташаа мэдээлэл байвал зөвхөн зохиогчийн буруу болно. Энэхүү ажил нь зөвхөн хувь судлаачийн байр суурийг илэрхийлэх бөгөөд МУИС болон МУИС-ийн Эдийн засгийн тэнхимийн байр суурь биш болно.

© Зохиогч(ид). 2019 Нээлттэй нэвтэрнэ. Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэл Creative Commons Attribution 4.0 (<http://creativecommons.org/licenses/by/4.0/>) гэх олон улсын лицензийн нөхцлийн дагуу тараагддаг бөгөөд энэ нь анхны зохиогчид болон эх сурвалжийг зохимжтой байдлаар иш татаж дурдсан, Creative Commons лицензийн вэб холбоосийг оруулсан болон ямар нэгэн өөрчлөлт хийсэн эсэхээ дурдсан тохиолдолд тус өгүүлэлийг хязгааргүй ашиглах, түгээх, ба хуулбарлахыг зөвшөөрнө.



# Ranking of Mongolian economists and economic institutions

Erdenebat Bataa

National University of Mongolia

*Received: 2020.09.28; Revised: 2020.11.06; Accepted: 2020.11.07*

**Abstract:** This article provides the first academic ranking of Mongolian economists and economic institutions, to gauge where we are at in terms of international standards, what requirements and incentive mechanisms are necessary for our further advancement. Only 8.6% of the 751 economists considered in this study, only 6.6% of the 530 economics doctorate holders and only 3 of the 34 universities and colleges that are permitted to provide economics training at the undergraduate and higher levels by the Ministry of Education and Science have publications in *Web of Science* and *Scopus* indexed journals. None of the 37 Mongolians who obtained the Soviet Union's and Russia's Doctor of Science degrees, 1 one out of 18 holders of the Mongolian version of such degrees, 1 one economics professor titleholder, only 1 out of 7 Academicians, only 2 out of the 23 full-professors and only 4 out of 41 associate professors have such publications. This finding indicates that we need to raise requirements and expectations for our economics doctors, their thesis supervisors and defence committee members, professors and academicians. Replication data and *R* codes of this study are made publicly available, and I ask colleagues in other scientific fields to conduct similar investigations.

**Keywords:** Academic economist, Scientific advancement, Ranking, Mongolia;

**JEL classification:** A1,H83,I23.

---

Department of Economics, Building V, Room 603, Ulaanbaatar, Mongolia. Phone: +976-95343365, email: tsors79@yahoo.com;

This version has benefited substantially from the comments of the co-editors, Ninjbat Uganbaatar, Gan-Ochor Doojav and Gerelt Tserenjigmid, as well as those received at the Mongolian Economic Association and a seminar at the National University of Mongolia. All errors and omissions are mine. The views expressed here are those of the author, and not necessarily those of the Department of Economics.

© The Author(s). 2019 Open access. This article is distributed under the terms of the Creative Commons Attribution 4.0 International License (<http://creativecommons.org/licenses/by/4.0/>), which permits unrestricted use, distribution, and reproduction in any medium, provided you give appropriate credit to the original author(s) and the source, provide a link to the Creative Commons license, and indicate if changes were made.

## 1 Удиртгал

Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2020 оны 8 дугаар сарын 21-ний А/32-р тушаалаар миний бие “Шилдэг эрдэм шинжилгээний өгүүлэл хэвлүүлсэн судлаачийг шалгаруулах, урамшуулал олгох журам” боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийн гишүүнээр томилогджээ. Үүнийг нь юуны өмнө эдийн засагчийнхаа хувьд ийм төрлийн урамшуулал байх ёстой эсэх, байвал хэний ямар өгүүллийг, хэрхэн урамшуулах ёстой вэ, өмнөх туршлага ямар үр дагавартай байв гэдэг маш чухал ч, тун ярвигтай, маргаантай асуудлаар аль болох үндэслэлтэй зөвлөгөө боловсруулахыг шаардаж байна гэж хүлээн авлаа<sup>1</sup>. Уг ажлын хэсэгт орсон бусад гишүүд ч ийм төрлийн судалгаа хийж буй гэдэгт эргэлзэхгүй байна.

Аливаа улсын хувьд стандартчилагдан хэмжигдэж, харьцуулагдаж болох, шинжлэх ухаанд хувь нэмэр оруулсан эрдэм шинжилгээний ажлууд нь шинжлэх ухаан, шинэ технологи дээд боловсролын тогтолцоогоор дамжин нийгэмд хэр тархаж буйн нэг хэмжигдэхүүн билээ. Шинэ мэдлэг бий болгох гэж оролдох нь ямар мэдлэг аль хэдийн бий болчихсон байна вэ гэдгийг тандаж мэдэхээс эхэлдэг болохоор тэргүүлэх их сургуулиуд зөвхөн шинэ мэдлэгийг бүтээсэн нь баримтаар нотлогдох багш нараас бүрддэг нь нийтлэг жишиг юм.

БШУЯ (2020)-ны статистикаар эдийн засгийн мэдлэг зайлшгүй шаардлагатай нийгмийн болон зан үйлийн шинжлэх ухаан, бизнес удирдлагын чиглэлээр 2019-2020 оны хичээлийн жилд бакалаврын түвшинд 27091, магистрт 10526, докторт 981 хүн бүртгэлтэй байсан нь тухайн түвшний нийт оюутнуудын 22.7%, 40.9%, 28.9%-ийг тус бүр бүрдүүлж байжээ<sup>2</sup>. ҮСХ-ны статистикаар 2004 оноос хойших 15 жилд нийт 471422 хүн Монголын дээд боловсролын байгууллагуудыг төгссөн бөгөөд эдгээрийн 32.4% нь дээрх чиглэлүүдийнх байжээ. Энэ нь Монгол дахь эдийн засгийн шинжлэх ухааны хөгжлийн түвшин нь нийгмийн хөгжлийг тодорхойлогч нэг үндсэн хэсэг болохыг харуулж байна. Иймд судалгааны чанарын асуудал нь технологи дамжуулалтыг бакалавр, магистр, докторын сургалтын түвшинд хэн хэрэгжүүлэх, их сургуулийн багш нарын зэрэглэлийг ямар үзүүлэлт дээр үндэслэн тогтоох, мэргэжлийн удирдлагаар хэн хангах ёстой вэ гэх мэт чухал асуудлуудтай маань мөн холбоотой юм.

Маргаанид хүргэх эрдэмтэд, багш нараа урамшуулахдаа бид өнгөрсөн үеэ сайтар ойлгож, өнөөдөр хаана байгаагаа тогтоох ёстой. Гурван аравны тэртээ зүүн Европын улсууд, ЗСБНХАУ-д төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцоо, социализм нуран унахад зөвлөлтийн математикжсан эдийн засгаас бусад эдийн засгийн шинжлэх ухааны салбарууд, боловсролын түвшин дэлхийн жишгээс асар их хоцрогдсон байсныг Alexeev, Clifford & Leitsel (1992), Brue & MacPhee (1995) нар цохон тэмдэглэсэн байдаг. Хэдийгээр Марксист эдийн засгийн урсгал баруунд байдаг ч энэ нь хуучин социалист улсуудын үзэл сурталжсан Марксизм-Ленинизмын хувилбараас ялгаатай хэмээн Barnett (2005) дүгнэсэн байдаг бөгөөд, БНМАУ-ын эдийн засагчдын хувьд хуучин социалист системийнхээ эдийн засгийн гол сэтгүүлүүд болох “Проблемы экономики”, “Вопросы экономики”, “Плановое хозяйство” гэх мэтэд бүтээлээ нийтлүүлж байсан баримт одоогоор олдоогүй байна.

Хуучин социалист улсуудын эдийн засгийн боловсрол, судалгааны чадавхийг дээшлүүлэх

<sup>1</sup> МУИС “Web of Science (WoS)”-ийн оноотой сэтгүүлд бүтээлээ нийтлүүлсэн багш, ажилчдыг нэгдүгээр, холбоо баригч, хамтран зохиогч байсан эсэхээс нь хамааруулан, нийтлүүлсэн тоонд нь тулгуурлан мөнгөн урамшуулал олгож эхлээд 10-аад жил болж байна.

<sup>2</sup> Монголд төрийн өмчийн 14 их сургууль, 7 дээд сургууль, хувийн өмчийн 21 их сургууль, 43 дээд сургууль, 7 коллеж, нийт 95 дээд боловсролын байгууллага үйл ажиллагаа явуулж, 148446 оюутан суралцаж байна (БШУЯ, 2020).

нь гэсэн 20 жил үргэлжилсэн хөтөлбөрийг Дэлхийн банкнаас 1990-ээд оны эхээр хэрэгжүүлсэн ч Монгол үүнд нь хамрагдаагүй үлдсэн байдаг (Bourguignon, Elkana & Pleskovic, 2007)<sup>3</sup>. Энэ нь бусадтай харьцуулахад дэлхийн жишгээрх эдийн засгийн шинжлэх ухааны цөөхөн ч болов эрдэмтэд Монголд байгаагүй, эсвэл эдийн засгийн эрдэмтэд гэгдэх хүмүүс нь өөрсдийн статусаа алдахаас зайлсхийсэн шийдвэртэй нь холбоотой байж болох бөгөөд, тийм бол цаашид залруулах ёстой алдаа юм<sup>4</sup>. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн харилцаанд шилжээд 10 жил болсны дараа ч гэсэн олон улсын жишигт нийцсэн эдийн засгийн докторын хөтөлбөр хуучин социалист улсуудад байхгүй байна, өөрөөр хэлбэл шинжлэх ухааны суурь гэх зүйл алга хэмээн Pleskovic, Aslund, Bader & Campbell (2000) дүгнэсэн байдаг. Магадгүй үүнтэй холбоотойгоор Хятад улс эдийн засгийн докторын зэргийг сүүлийн үед *WoS*-ийн сэтгүүлүүдэд 2 болон түүнээс дээш өгүүлэл нийтлүүлсэн тохиолдолд л олгодог байх хатуу шаардлагыг тавьдаг болжээ<sup>5</sup>.

Манай улсын хувьд шилжилтийн эхэнд эдийн засгийн эрдэм шинжилгээ, боловсролын тогтолцоо маань ямар байсан талаар Монгол улсын эдийн засгийн дээд боловсролын шинэчлэлд хувь нэмэр оруулах зорилготой байсан Европын Холбооны *TACIS* хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн тайлангуудад, тухайлбал Hall & Thomas (1999), Nixon, Suvd, Luvsandorj & Walters (2000)-д цухас харьцуулагдсан байдаг. Мэдээж монголчуудын эдийн засгийн шинжлэх ухааны сэтгэлгээний түүх, амжилтын талаар эерэг үзэл бодол түгээмэл. Жишээ нь, Засгийн газрын дэргэдэх Төрийн бодлого судлах төвийн захирал, УИХ-ын гишүүн, Төсөв санхүү, мөнгө зээлийн бодлогын байнгын хорооны гишүүн, Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн ректор асан, Удирдлага, эдийн засаг, сургалт, эрдэм шинжилгээний байгууллагуудын консерциумын гүйцэтгэх захирал, “Этүгэн” их сургуулийг үүсгэн байгуулагч, Монгол улсын гавъяат эдийн засагч, академич С. Нямзагд (2019) өөрийн багш, академич П.Лувсандоржийн шинжлэх ухаанд оруулсан гол хувь нэмрийг “... К.Марксын нөхөн үйлдвэрлэл явагдах 3 нөхцөл байдгийг шинжлэн судлаад борлуулалтын 4 дэх нөхцөл, түүний томъёог гаргасан юм. Үүгээрээ Дэлхийн эдийн засгийн онолын сэтгэлгээнд өөрийн мөнхийн хөшөөг босгож чадсан билээ. Одоо ч энэ дайны дорвитой сэтгэлгээний бүтээлийг Монголчууд бид гаргаж чадахгүй л байна...” хэмээн дүгнэсэн байдгаас үүнийг харж болно.

Boone (1994) монголчууд коммунист улс төрийн тогтолцоо, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас ардчилал, зах зээлийн харилцаанд шилжих улс төрийн хүчин зүйлс, институцүүдийг л авч үзэж, харин эдийн засгийн асуудлууд, тухайлбал шилжилтийн хурд, дараалал, зах зээлийн институцүүдийг хөгжүүлэх асуудлуудыг орхигдуулж байгааг дурдсан байдаг. Мөн Walters, Hall, Nixon & Stubbs (1999) Монголд түүхэн болон эдийн засгийн нөхцөл байдлаа мэддэг, сайн бэлтгэгдсэн, өөрийн гэсэн эдийн засагчид дутагдаж байгааг цохон тэмдэглэжээ. Магадгүй иймдээ ч нийгэм-эдийн засгийн аливаа шийдвэрт зөвхөн олон улсын байгууллагуудын амыг дагаж, “барууны хэт либералуудын хонгор”, “либерал хөгжлийн эдийн засгийн онц сурагч” (Griffin, Brenner, Kusago, Ickowitz & MicKinley, 2001), “гадаад зөвлөхүүдийн диваажин” (Luvsanjants & Soderberg, 2005) нэр хоч зүүж, Rossabi (2005)-ийн дүгнэснээр донор байгууллагуудын тавьсан нөхцөлүүдийн

<sup>3</sup> Нөгөө 2 нь иргэний дайнтай байсан Босни-Херцеговин, Югослав улсууд юм.

<sup>4</sup> Хаант Орос улс, ЗХУ-аас эдийн засгийн тэргүүлэх эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлүүлсэн өгүүллийн товчоон Campbell (2012)-д бий. Социализмын үед зүүн Европын эдийн засагчид П. Самуелсоны “Economics” сурах бичгийн хуулбарыг нууцаар дамжуулан уншдаг байсан талаарх Прагийн эдийн засгийн сургуулийн захирлын дурсамж Shirley (2008)-д бий. Монголын хувьд ийм баримт одоогоор мөн олдоогүй байна.

<sup>5</sup> Зарим сургуулиуд нь арай хөнгөн, төгссөнөөс хойш 2 жилийн дараа нийтлүүлнэ, үгүй бол зэргийг нь цуцална гэсэн нөхцөл тавьж байна. Жишээ нь, дунджаас дээш сургуулийн төлөөлөл болох Жейжаны их сургуулийн хүлээн зөвшөөрдөг 143 сэтгүүлийн нэрийг <https://bit.ly/3izwCOo> -ээс үзэж болно.

дагуух туршилтын лаборатори нь болсон бизээ.

Энэхүү ажлаар монгол академик эдийн засагчид, их дээд сургуулиудыг олон улсын жишгийн дагуу үнэллээ. Судалгааны үр дүнгээ урьдчилан тоймолбол ЗХУ болон ОХУ-ын докторын дээд зэрэг болох *Доктор экономических наук (ДЭН)*-тай 36 монгол хүнээс ганц нь ч, эдийн засгийн профессор цолтонгууд, дотоодын дээд зэрэг болох шинжлэх ухааны доктор (*ScD*) 18 хүн, эдийн засгийн салбараарх Монгол Улсын ШУА-ийн 7 академичаас ганцаас бусад нь, БШУЯ-аас эдийн засгийн бакалавр болон түүнээс дээш зэрэг олгох зөвшөөрөл авсан 34 их, дээд сургуулиас гурваас бусад нь, мэдээлэл нь нийтэд ил эдийн засгийн 23 профессороос 2-оос бусад нь, 41 дэд профессороос 4-өөс бусад нь олон улсын хэмжээний эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлүүлсэн бүтээлгүй байгаа нь эдийн засгийн шинжлэх ухаан Монголд нэвтэрч чадахгүй байгаагийн нотолгоо, харангын дохио болж байна. Дараах хэсэгт энэ асуудлын судлагдсан байдлыг танилцуулна. 3-р хэсэгт эдийн засагчид болон сургалт, судалгааны байгууллагуудыг хэрхэн үнэлэх арга зүйгээ, харин 4-р хэсэгт эрдэмтдийн талаар цуглуулсан өгөгдөл, түүний онцлогуудыг танилцуулна. 5-р хэсэгт үндсэн үр дүнгээ танилцуулж, 6-р хэсэгт бодлогын зөвлөмжөөр үргэлжлүүлж түүний дараа дүгнэнэ.

## 2 Судлагдсан байдал

Аливаа зүйлийг хэмжихгүйгээр сайжруулах боломжгүй билээ. Гэвч Монгол улсад орчин үеийн эдийн засгийн шинжлэх ухаан бусад улсуудтай харьцуулахад хэрхэн хөгжиж байгаа, эрдэмтэд нь ямар чадавхитайг тогтоох оролдлого одоогоор хийгдээгүй байна. Харин бусад улсын хувьд эдийн засагчид болон их, дээд сургууль, судалгааны байгууллагуудыг үнэлсэн судалгаа түгээмэл. Жишээ нь баруун Европ, хойд Америкийн хувьд Lubrano, Bauwens, Kirman & Protopopesc (2003), Neary, Mirrlees & Tirole (2003), Drèze & Estevan (2007), Дэлхийн хувьд Coupè (2003), Kalaitzidakis, Mamuneas & Stengos (2003, 2011) болон Amir & Knauff (2008)-ыг дурдаж болно. Харин бидэнтэй адил төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн харилцаанд шилжсэн Балканы бүс нутаг болон Төв Ази, Кавказын нурууны улсуудын судалгааг Çokgezen & Çokgezen (2014, 2015) хийсэн байдаг.

Улс дотроо мөн ийм төрлийн чансааны жагсаалтыг тогтмол гаргадаг. Жишээ нь, АНУ-ын хувьд Conroy & Dusansky (1995), McPherson (2012), Австралынхыг Neri & Rodgers (2015), Шинэ Зеландынхыг Macri, McAleer & Sinha (2010), Туркийнхыг Çokgezen (2019), Израйлынхыг Ben-David (2010) Солонгосынхыг Jin (2019) гэх мэтээс харж болно. Хуучин социалист байсан улсуудын хувьд Хятадынхыг Yu & Gao (2010), Leeves & Poon (2015), Оросынхыг Kirtchik (2012), Шумилов & Балацкий (2016), Чехийнхыг Munich (2006), Украйныхыг Mirucki (1999), Coupè (2008), Словакынхыг Ciaian, Lancaric & Pokrivcak (2018)-аас гэх мэт үзэж болно. Ийм жагсаалтаа урамшуулал болон санхүүжилтийн тогтолцоотойгоо уялдуулах нь ч элбэг. Жишээ нь Heckman & Mocktan (2020) АНУ-ын их сургуулиудад багш нарын цалин нь эдийн засгийн тэргүүлэх сэтгүүлүүдэд нийтлүүлдэг эсэхтэй холбоотой байдаг тухай дурдсан байна. Их сургуулиудын санхүүжилтийг ч судалгааны үзүүлэлтүүдтэй нь уялдуулах нь түгээмэл бөгөөд Их Британий Судалгааны салбарын аттестатчилал (Research Area Exercise, RAE), Австралийн Үндэсний судалгааны үнэлгээ (National Research Assessment, NRA) гэсэн хөтөлбөрүүдийг энд жишээ болгон дурдаж болох юм.

Эдийн засагчдынх нь хэн нь хэн бэ гэдгийг олон нийтэд нээлттэй танилцуулахад ч мөн өндөр ач холбогдол өгч байна. Жишээ нь Словакын эдийн засгийн холбооноос гаргадаг Словак гаралтай эдийн засагчдын чансааны жагсаалт (<https://www.econrank.sk>), Герман,

Хүснэгт 1. *EDIRC*-д бүртгэлтэй нэгж, судлаачид

Нэгж	Судлаач	
	Бүтээлтэй	Бүтээлгүй
1 МУИС-ийн Эдийн засгийн тэнхим	9	6
2 Монголбанк	7	6
3 Удирдлагын академи	2	1
4 Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн (ERI)	2	1
5 МУИС-ийн Бизнесийн сургууль	1	-
6 МУИС-ийн Олон улсын харилцааны сургууль	1	-
7 Дэлхийн банкны Улаанбаатар дахь салбар	1	-
8 Цахим өртөө коллеж	1	-
9 Санхүү, эдийн засгийн их сургууль	-	4
10 Санхүүгийн зохицуулах хороо	-	2
11 Сангийн яам	-	1
12 Аж үйлдвэр, хөдөө аж ахуйн яам	-	1
Нийт	24	22

Эх үүсвэр: <https://edirc.repec.org/mongolia.html>. 2020 оны 10-р сарын байдлаар.

Австри, Швейцари гаралтай эдийн засагчдыг эрэмбэлдэг Германы бизнесийн тэргүүлэх сонин *Handelsblatt*-ын (<https://www.forschungsmonitoring.org/ranking>) олон нийтэд зориулсан цахим жагсаалтуудыг энд дурдаж болно. Эдгээрээс хамрах улс, байгууллага, эдийн засагчдын тоо, болон судалгааны үр дүнг тооцох аргачлалаараа хамгийн том нь АНУ-ын төв банкнаас санхүүжүүлдэг, төрөл бүрийн хэл дээрх, 102 улсын 2000 гаруй цахим архивын 3500 сэтгүүл, 5000 цуврал препринт (working paper series), 36 компьютер кодын сан, 490 номын цуврал, 209 номын бүлэг гэсэн 5 төрлийн, нийт 3.2 сая судалгааны материалыг агуулдаг *Research Papers in Economics* (Эдийн засгийн судалгааны ажлууд, *RePEc*) сан юм (<http://repec.org>). Уг санд МУИС-ийн Эдийн засгийн тэнхимийн, Монголд болон өндөр хөгжилтэй улсуудад багшилдаг эрдэмтдээс бүрдсэн редакцийн зөвлөл бүхий *Эдийн засаг: Онол, Практик (ЭЗОП)* сэтгүүл бүртгэгдэхээр хөөцөлдөж байгаа ч уг сэтгүүлд нийтлүүлэх сонирхол хангалттай хэмжээнд хүрэхгүй байгаа учир энэ оролдлого зогсонги байдалтай байна<sup>6</sup>. Харин ОХУ-аас бүртгэлтэй эх сурвалжууд байнга нэмэгдэж байгаа бөгөөд 2016 оны 4-р сарын байдлаар 74 сэтгүүл, 15 цуврал препринт Орос хэл дээр байжээ (Шумилов & Балацкий, 2016).

2020 оны 10-р сарын байдлаар дэлхийн 14687 эдийн засгийн тэнхим, хүрээлэн, судалгааны төв, тэдгээрт ажиллагсдын бүртгэл бүхий *Economics Departments, Institutes and Research Centers (EDIRC)* гэсэн *RePEc*-ийн дэд сан нь Дэлхийн 182 улс, АНУ-ын 50 мужийн 8140 нэгж, байгууллага, 59325 эдийн засагчийг хамарч буй бөгөөд Монголоос ердөө 8 нэгж, 22 хүний бүтээл бүртгэлтэй байгааг Хүснэгт 1-д харуулж байна<sup>7</sup>. Улс болгоны (АНУ-ын хувьд мужуудын) хувьд эхний 1/4-д эрэмбэлэгдэж байгаа нэгж, эдийн засагчдын мэдээллийг нийтэд зарладаг бөгөөд үлдэх хүмүүсийн имейл хаяг руу нь дэлгэрэнгүй тайлан, ижил түвшний судлаачдын мэдээлэл болон чансаагаа ахиулахын тулд юу хийх ёстой талаар сар бүр зөвлөмж илгээдэг. Ингэхдээ нийт бүртгэлтэй ажил, эшлэл, эшлэсэн зохиогчийн тоо, h-индекс, нийтлүүлсэн сэтгүүлийн хуудасны тоо, өмнөх сард ажлуудаас нь татаж авсан (download) тоо гэх мэт 38 үзүүлэлтийг ашиглан эхлээд зохиогчдыг, дараа нь тэднийг нэгтгэн байгууллагуудыг эрэмбэлдэг ажээ.

<sup>6</sup> <http://econjournal.mn/>. 2019-2020 оны хичээлийн жилд уг сэтгүүлд нийтлүүлэхээр 4 ажил ирсэн бөгөөд 2-ыг нь хөндлөнгийн шүүгчдийн дүгнэлтээр нийтлэхээс татгалзжээ.

<sup>7</sup> Бүртгүүлэх нь *Facebook*, *Twitter*-д бүртгүүлэхтэй ижил. Үүний дараа эрдэмтний судалгааны ажлуудыг нь компьютерийн роботууд интернетээс хайж эрэмбэлдэг.



**Хүснэгт 2. IDEAS-ын чансааны жагсаалт**

Нийт хугацаа	Оноо	Сүүлийн 10 жил	Оноо
Эдийн засагчид			
1. Д.Лхагвасүрэн	1.26	1. Д.Лхагвасүрэн	1.22
2. Г.Рагчаасүрэн	3.1	2. Б.Эрдэнэбат	2.5
3. Ж.Андерсон	3.2	3. Д.Ган-Очир	4.35
4. Б.Эрдэнэбат	3.53	4. Г.Рагчаасүрэн	4.79
5. Д.Ган-Очир	4.84	5. Б.Алтанцэцэг	4.89
6. Б.Алтанцэцэг	6.92	6. Н.Батсайхан	6.47
Байгууллагууд <sup>8</sup>			
1. МУИС, Бизнес сургууль	1.46	1. МУИС, Бизнес сургууль	1.53
2. Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн (ERI)	2.84	2. МУИС, ЭЗ-ийн тэнхим	2.36

Топ-25%-ийн эдийн засагч болон байгууллагын нийт болон сүүлийн 10 жилийн бүтээлээрх эрэмбэ 2020 оны 10-р сарын байдлаар. Эх үүсвэр: <https://ideas.repec.org/top/top.mongolia.html>.

Хүснэгт 2-т энэ санд монгол эдийн засагчид болон нэгж, байгууллагуудыг нийт болон сүүлийн 10 жилийн судалгааны ажлуудаар нь хэрхэн эрэмбэлж буйг харуулж байна. Энд МУИС-аас бусад Монголын их, дээд сургуулиуд болон судалгаа, шинжилгээний ажлаар дагнан, төсвөөс санхүүжигддэг Шинжлэх ухааны академи болон бусад эдийн засгийн судалгаа шинжилгээний хүрээлэнгүүд огт байхгүй байгаа нь, гадаад хүн ч бүртгүүлж буй нь анхаарал татаж байна. Мөн МУИС-ийн Эдийн засгийн тэнхим нийт хугацаагаар эхний 2 байрт орж чадахгүй байгаа нь дотооддоо чадварлаг судлаачдыг татаж чадахгүй байгаагийн нэг илрэл юм.

Хэдийгээр уг жагсаалт нь хамрах хүрээний хувьд өргөн ч хамрагдах эсэх болон ямар харьяалалтай бүртгүүлэхээ судлаач өөрөө шийддэг, “идэвхтэй оролцооны зарчим” дээр тулгуурладаг нь Монголоос хэт цөөн хүн, байгууллага эрэмбэлэгдэхэд хүргэж, найдвартай байдалд нь эргэлзээ төрүүлж байна. Мөн татан буугдсан нэгжийг хасдаггүй (Цахим өртөө коллеж), гадаадад сурч, ажиллаж байгаа Монгол эдийн засагчид хамрагдахгүй байгаа нь эдийн засгийн шинжлэх ухааны хөгжлийн түвшинг маань үнэлэхэд учир дутагдалтай байж болох юм.

### 3 Арга зүй

Эдийн засгийн шинжлэх ухааны судалгааны хамгийн чухал үр дүн бол хөндлөнгөөс хянан магадлагддаг сэтгүүлд нийтлүүлсэн өгүүлэл байдаг. Бусад судалгааны үр дүнгүүдийн хувьд эдийн засагчид патентын эрх авах нь тун ховор. Харин ном, эсвэл номын бүлэг бичих, эрдэм шинжилгээний хурал, семинарт оролцох нь хянан магадлагддаг сэтгүүлд бүтээлээ нийтлүүлэхийн дагавар, эсвэл хослол нь байдаг. Sokgezen (2019) бусад ийм судалгааны ажлын үр дүнг харьцуулахад яагаад төвөгтэй байдаг талаар дэлгэрэнгүй тайлбарлажээ.

УИХ-ын 12-р тогтоолоор батлагдсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-д Монголын дөрвөөс доошгүй их сургуулийг Азийн топ 100 сургуулийн эгнээнд хүргэнэ гэсэн зорилт, МУИС энэ амжилтанд 2024 онд хүрнэ хэмээн тусгасан стратегийн тө-

<sup>8</sup> МУИС-ийн ЭЗ-ийн тэнхимийн зочин профессор Д. Лхагвасүрэн татан буулгасан МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн харьяаллаар бүртгүүлсэн, уг домайныг нь МУИС-ийн Бизнесийн сургууль авчихсантай холбоотой харьяаллын алдаа гарсан байгаа.

лөвлөгөөнд дурдагдсан Их Британы *Times Higher Education* сэтгүүлээс гаргадаг *World University Rankings (THE)*, мөн улсын *Quacquarelli Symonds* компаниас гаргадаг *QS World University Ranking (QS)* болон урд хөршийн *ARWU World University Ranking (ARWU)*-ын их сургуулиудын чансааны жагсаалтад ч сэтгүүлийн өгүүллүүд шийдвэрлэх хувийг эзлэдэг. Тухайлбал *QS*-ийн 20%, *THE*-ийн 36%, *ARWU*-ийн 70% олон улсын хэмжээний сэтгүүлд нийтлүүлсэн өгүүллийн тоо болон чанараас шууд хамаардаг. Энэ ажлын хүрээнд ч зөвхөн эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлэгдсэн болон хэвлэхээр зөвшөөрөгдсөн (accepted) өгүүллүүдийг ашиглан эрдэмтэд, дээд боловсролын, мэргэжлийн болон бусад байгууллагуудын чансааг гаргана.

Чансааг тогтоохдоо ашиглах өгүүллийн олонлогийг хэрхэн тогтоосноор нь өмнөх судалгааны ажлуудыг гурав ангилж болно. Юуны өмнө мэргэжлийн холбоод, зөвлөллүүд өөрсдийн жагсаалтыг гаргах нь бий. АНУ-ын Эдийн засгийн холбооноос гаргадаг, өдгөө 1000 орчим сэтгүүлтэй *EconLit* санг Mirucki (1999), Coupe (2008), Macri *et al.* (2010) ашигласан байдаг. Мөн эдийн засгийн салбарт А\*, А, В, С гэсэн 4 зэрэглэлийн 643 сэтгүүлтэй Австралийн бизнесийн сургуулиудын захирлуудын зөвлөлийн жагсаалт (<https://abdc.edu.au/research/abdc-journal-list>), эдийн засаг, эконометрик, статистикаар 4\*, 4, 3, 2, 1 гэсэн 5 зэрэглэлийн 332 сэтгүүлтэй Английн бизнес сургуулиудын холбооны жагсаалтыг (<https://charteredabs.org/academic-journal-guide-2018/>) энд дурдаж болно. Эдгээрээс зөвхөн топ зэрэглэлийн сэтгүүлүүдийг нь, тухайлбал Pieters & Baumgartner (2002) шиг топ-5, Conroy & Dusansky (1995) шиг топ-8-ыг ашиглах нь олонтаа. Гэвч топ сэтгүүлийн хуудасны тоо нь хязгаарлагдмал атал нийтлэгдэж буй өгүүллүүдийнх нь дундаж урт нэмэгдсэн, ялангуяа социализмын дараа эрдэмтдийн тоо эрс өссөнтэй холбоотойгоор эдгээрт нийтлүүлэх нь үндсэндээ боломжгүй болсон (Card and DellaVigna, 2013). Энэ нь “топ” гэгдэх сэтгүүлүүдийн олонлогийг өргөтгөх олон санаачлагуудыг гаргаж буй бөгөөд Kalaitzidakis, Mamuneas & Stengos (2003, 2011)-ын топ-35, Leever & Poon (2015)-ын топ-35, Neri & Rodgers (2014)-ийн топ-45, McPherson (2012)-ийн топ-50 эдгээрийн жишээ юм.

Эдийн засагчдийн өөрсдийнх нь гаргасан жагсаалтаас гадна *Web of Science (WoS)*, *Scopus* гэсэн шинжлэх ухааны олон салбарыг хамарсан, ном, хэвлэлийн чанарын үнэлгээний (библиометр, bibliometry) мэдээллийн баазуудыг мөн ашиглах нь бий. Жишээ нь, Munich (2006), Yu & Gao (2010), Kirtchik (2012), Ciaian *et al.* (2018), Jin (2019), Çokgezen (2019) *WoS*-ийн Сэтгүүлийн эшлэлийн тайлангийн (*Journal Citation Report, JCR*) импакт фактор оноог (*impact factor, IF*) ашигласан бол Çokgezen & Çokgezen (2014, 2015) *Scopus* санг ашигласан байдаг. МУИС (2012)-ийн Багшийн орон тоо, ажлын үнэлгээний журамд *WoS*-ийн импакт факторыг баримтлан хамгийн өндрөөр үнэлэхээр заасан байдаг бол үүний дараа МУИС (2014)-ийн Профессор, багш ажиллуулах журамд “... бусад үнэлгээний системүүдийг /Scopus г.м./ дүйцүүлэн тооцох боломжтой ...” хэмээн өргөтгөсөн байдаг.

Дээрх хоёроос гадна судалгааны ажлыг хэвлэгдсэн сэтгүүлээр нь бус өөрийг нь үнэлэхэд илүү боломж олгодог *Google Scholar (GS)*-ыг Ben-David (2010), Combes & Litterman (2010), Laband (2013) ашигласан байна. Wouters *et al.* (2015) *GS*-ын давуу талыг “өөр өөр улсуудад, төрөл бүрийн хэл дээр хэвлэгддэг маш олон эрдэм шинжилгээний сэтгүүл болон шинжлэх ухаантай холбоотой материалуудыг хамардгаараа *WoS* болон *Scopus*-ын орхигдуулсан газрууд дахь судалгааны нөлөөний үнэлгээг тогтооход чухал хэрэгтэй байж болох юм” гэж дүгнэсэн байдаг. Үнэгүйгээрээ *WoS* болон *Scopus*-аас ялгаатай *GS* нь судлаачийн ажлуудын нийт эшлэлийн тооноос гадна судлаачийн *h*-ээс дээш тооны эшлэлтэй *h* судалгааны ажлынх нь тоо болох *h*-индекс болон 10-аас дээш эшлэлтэй судалгааны ажлын тоог илтгэх *i10* индексийг гарган өгдөг. Сул тал нь *RePec*-тэй нэгэн адил судлаач *GS*-ын данс нээх эсэхээ шийддэг.

Энэ судалгааны хувьд *GS*-ын статистикуудаас гадна топ-5, топ-8, топ-35, *WoS* болон *Scopus*-ын сэтгүүлд нийтлүүлсэн тоо, дор нарийвчлан тодорхойлох *WoS*-ийн импакт фактор (*impact factor, IF*), айгенфактор оноо (*eigenfactor score, EFS*), өгүүллийн нөлөөний оноо (*article influence score, AIS*), *Scopus*-ын эшлэлийн оноо (*CiteScore*), эх үүсвэрийг нь нормалчилсан өгүүллийн нөлөө (*Source-normalized Impact per Paper, SNIP*), *Scimago*-гийн сэтгүүлийн ранк (*Scimago Journal Rank, SJR*) оноонуудыг ашиглана.

Топ-35 сэтгүүлийн хувьд хэдийгээр харьцангуй хуучин ч, тогтмол шинэчлэгддэг Тилбургийн их сургуулиас гаргадаг Дэлхийн их сургуулиудын судалгааны чансааны жагсаалтад (<https://econtop.uvt.nl>) ашиглагддаг Kalaitzidakis *et al.* (2003, 2011)-ыг ашиглав<sup>9</sup>. Уг жагсаалт топ-35 сэтгүүлийнхээ *IF*, *AIS*-ийг нь ашиглан их сургуулиудыг эрэмбэлдэг нь эдийн засагчдын болон библиометрийн арга зүйг нэгтгэж буй онцлогтой.

Оноо ашиглахад сэтгүүлүүдийн тус бүрийн чансаанаас гадна зохиогчдын тоог авч үзэх шаардлагатай. Энэхүү судалгаанд Lubrano *et al.* (2003)-ийн нэгэн адил  $i$ -р судлаачийн  $j$ -р сэтгүүлд нийтлүүлсэн оноо  $q_{i,j}$ -г

$$q_{i,j} = \frac{b(p_j)}{a(p_j)} v(p_j) \quad (1)$$

гэсэн томъёог ашиглан тооцох бөгөөд энд  $b(p)$  нь судалгааны ажлын хэмжээтэй холбоотой утга,  $a(p)$  нь тухайн ажилд оролцсон нийт  $n$  зохиогчийн тоотой холбоотой хэмжээс,  $v(p)$  нь тухайн ажлын чанарыг илтгэнэ.

Уг судлаачийн  $T$  хугацаанд,  $l$  судалгааны ажлаасаа цуглуулсан нийт оноог

$$s_i = \sum_{t=1}^T \sum_{j=1}^{l_{i,t}} q_{i,j,t} \quad (2)$$

гэж тооцох бөгөөд энд  $l_t$  нь  $t$ -р жилд нийтлүүлсэн өгүүллийн тоо (бүхэл байх албагүй) юм. Харин  $k$ -р байгууллагын чансааг гаргахдаа Монголын их дээд сургууль, байгууллагуудыг тус бүрд нь, харин гадаадад ажиллаж байгаа эдийн засагчдыг хамтад нь

$$S_k = \sum_{i=1}^K s_{i,T} \quad (3)$$

гэж бүлэглэх бөгөөд  $K$  нь уг нэгжийн судалгааны ажилтай эдийн засагчдын тоо,  $T$  нь судлаачийн нийт ажилласан жил болно.

Зарим судлаачид тэмдэглэл болон богино өгүүллүүд нь урт хэмжээтэй өгүүллүүдтэй харьцуулахад (дуурайлган хийсэн буюу *replication* ажил нь оригиналаасаа) шинжлэх ухааны ач холбогдол багатай гэж үзэх нь бий. Тэгэхээр нэг сэтгүүлд, эсвэл ижилхэн чансаатай 2 сэтгүүлд нийтлэгдсэн 2 өгүүлэл хуудасны тооноосоо болон оригинал ажил эсэхээсээ хамаарч өөр өөр оноотой байна гэсэн үг. Ингэхийн тулд зарим судлаачид ямарваа нэг сэтгүүлийн хуудсыг *American Economic Review* сэтгүүлийн хуудасны хэмжээ рүү стандартчилан хөрвүүлдэг бол Cribari-Neto, Jensen, Novo (1999) эконометрикийн 11 сэтгүүлийн хуудсыг эхлээд *Econometrica* сэтгүүлийн хуудасны хэмжээ рүү хөрвүүлсэн байдаг. Судалгаанд ашиглагдах нийт сэтгүүлүүдийг хамарсан стандартчилсан хуудасны тоо байхгүй, мөн Lubrano *et al.* (2003) ийнхүү хөрвүүлэх нь сэтгүүлийн чансаанд чанарын ялгаа гаргахгүй байна гэсэн үндэслэлээр  $b(p) = 1$  гэж үзсэнийг нь би мөн дагав. Энэ нь мөн салбаруудыг ялгаатай дүгнэхгүй байх ач холбогдолтой байж болно<sup>10</sup>.

<sup>9</sup> Уг жагсаалт мөн 44 өөр сэтгүүлийг нэмэлтээр ашиглах боломж олгодог.

<sup>10</sup> Энэхүү ач холбогдлыг санал болгосон Гэрэлтэд талархаж байна.



Дээр дурдсанчлан судалгааны ажлын чансаа буюу  $v(p)$ -г *WoS*-ийн *IF*, *EFS*, *AIS*, *Scopus*-ын *CiteScore*, *SNIP*, *SJR*-аар төлөөлүүлнэ. Анх 1964 онд Е. Гарфилдийн номын сангуудад ямар сэтгүүл захиалах шийдвэрт нь туслах зорилгоор үүсгэсэн *Science Citation Index*-ийг Томсон-Ройтерс компани өргөтгөн, өдгөө 12171 сэтгүүлд импакт фактор оноо олгодог болсон *JCR* болон бусад бүтээгдэхүүнтэй *WoS* гэсэн шинжлэх ухааны эшлэлийн индексийг 1997 оноос хөгжүүлсэн. Энэ нь Шинжлэх ухааны өргөтгөсөн эшлэлийн индекс (*Science Citation Index Expanded*), Нийгмийн ухааны эшлэлийн индекс (*Social Science Citation Index*), Урлаг & Хүмүүнлэгийн эшлэлийн индекс (*Arts & Humanities Citation Index*) гэсэн үндсэн салбаруудтай бөгөөд эрдэм шинжилгээний сэтгүүлүүд, хурлын эмхэтгэлүүдээс гадна сүүлийн үед цуврал номуудыг ихээр хамрах болж байна. Нийт 8-аас 371 сэтгүүлтэй 236 ангилал бүхий *WoS*-д эдийн засгийн харьяалалтай сэтгүүлүүд хамгийн олон нь бөгөөд эдийн засагчдын топ гэдэг сэтгүүлүүдийг бүгдийг агуулж байна.

*WoS*-ийн сэтгүүлийн **IF** гэж өмнөх 2 жилд уг сэтгүүлд нийтлэгдсэн өгүүллүүдээс *JCR*-д бүртгэлтэй сэтгүүл, ном, хурлын эмхэтгэлд эшлэгдсэн нийт тоог тухайн 2 жилд нийтлэгдсэн нийт өгүүллийн тоонд хуваасныг хэлдэг. Bergstrom *et al.* (2008) *IF*-ыг сайжруулан, *EFS*, *AIS* гэсэн үзүүлэлүүдийг санал болгосон байдаг (<http://www.eigenfactor.org>). **EFS** оноог тухайн сэтгүүлд сүүлийн 5 жилд нийтлэгдсэн өгүүллүүдийн тухайн жилд эшлэгдсэн тоон дээр тулгуурлан тооцдог. Эшлэлүүд нь өндөр эшлэгддэг сэтгүүлүүдээс ирсэн бол авах оноо нь харьцангуй өндөр байдаг. Мөн сэтгүүлийн өмнөх дугааруудад нийтлэгдсэн өгүүллийг тухайн сэтгүүлийн дараагийн дугааруудад эшлэсэн байвал тооцоололд оруулдаггүй учир сэтгүүлийн өөрийгөө эшлэх, редакцийн зөвлөлийнх нь *IF*-ийн хойноос зүй бусаар хөөцөлдөх асуудлаас зайлсхийдэг давуу талтай. **AIS** нь мөн тухайн сэтгүүлийн өгүүллүүдийн нийтлэгдсэнээсээ хойших 5 жилийн дундаж нөлөөг тодорхойлдог бөгөөд сэтгүүлийн хэмжээнийх нь *EFS*-д үзүүлэх нөлөөг арилгадгаараа давуу талтай гэдэг.

*Scopus* нь *Elsevier* хэвлэлийн компанийн бүтээгдэхүүн бөгөөд 1996 оноос хойш 14000 гаруй сэтгүүлд нийтлэгдсэн өгүүллүүдийн эшлэлийн тайланг гаргадаг (Bornmann, *et al.*, 2018). *Scopus*-ын салбарын ангилал *WoS*-ийнхоос харьцангуй сул, давхардал ихтэй байдаг. Тухайлбал энд *WoS*-ийнх шиг “Эдийн засаг (economics)” гэсэн нэг ангилал байхгүй, харин Эдийн засаг-эконометрик-санхүү гэсэн ерөнхий ангилал л байдаг. Үүний нэг дэд хэсэг болох эдийн засаг-эконометрикийн салбарт 637 сэтгүүл хамрагдаж байна. Гэвч эдгээрт топ-35 сэтгүүлээс *Journal of the European Economic Association*, *Journal of Health Economics*, эдийн засгийн бусад чухал сэтгүүлээс *American Economic Journal*-ууд хамрагддаггүй ажээ. Харин эдийн засаг-эконометрик-санхүү (янз бүрийн) гэсэн ангиллаарх 144, ерөнхий эдийн засаг-эконометрик-санхүү гэсэн ангиллаарх 228 сэтгүүлийг нэмбэл 997 сэтгүүл болж байна. Ийнхүү өргөтгөсний дараа ч *Journal of Health Economics* хамрагддаггүй<sup>11</sup>.

*Scopus*-ын сэтгүүлийн **CiteScore** нь *IF*-тэй төстэй. Энэ нь тухайн болон өмнөх 3 жилд нийтлүүлсэн өгүүллүүдийнх нь *Scopus*-д бүртгэлтэй сэтгүүл, хурлын өгүүлэл, өгөгдөл, номын бүлэгт эшлэгдсэн нийт тоог тухайн хугацаанд нийтлэгдсэн тийм судалгааны материалын нийт тоонд хувааж гаргадаг. **SNIP** нь шинжлэх ухааны салбарыг нь нормчилсон сэтгүүлийн нөлөө юм. Үүнийг сүүлийн 3 жилд нийтлэгдсэн өгүүллүүдээс нь тухайн жилд эшлэсэн нийт тоог сүүлийн 3 жилд нийтлэсэн өгүүллийн нийт тоонд хувааж тооцдог.  $SNIP=1$  гэдэг нь тухайн салбарт эшлэгдэлтээрээ медиан нь гэсэн үг. **SJR** нь

<sup>11</sup> *WoS*-ийн эдийн засаг, *Scopus*-ын энэ 3 дэд хэсэг аль алинд нь ордог 311 сэтгүүл байна. *WoS*-ийн сэтгүүлүүдийн нэр болон *IF*, *EFS*, *AIS*, тэдгээрт харгалзах *Scopus*-ын *CiteScore*, *SNIP*, *SJR* оноонуудыг топ сэтгүүлүүдийн ангиллын хамт Хавсралт-1-д харуулж байна. *Scopus*-ын сэтгүүлийн нэрсийн жагсаалтыг бүтнээр нь <https://www.scopus.com>-оос авч болох бөгөөд *WoS*, *Scopus*-ын сэтгүүлийн нийт нэрс, оноонуудыг судлаачийн <https://sites.google.com/site/erdenebatba/Home> гэсэн цахим хуудаснаас авч болно.

Хүснэгт 3. Үнэлгээний корреляци

	<i>AIS</i>	<i>EFS</i>	<i>IF</i>	<i>CiteScore</i>	<i>SNIP</i>	<i>SJR</i>
Топ-5	0.66	0.64	0.35	0.45	0.46	0.68
Топ-8	0.58	0.57	0.30	0.38	0.40	0.58
Топ-35	0.57	0.53	0.37	0.43	0.49	0.52
<i>AIS</i>		0.73	0.73	0.82	0.85	0.95
<i>EFS</i>			0.59	0.63	0.62	0.75
<i>IF</i>				0.95	0.87	0.75
<i>CiteScore</i>					0.88	0.74
<i>SNIP</i>						0.83

Топ сэтгүүлүүд болон үнэлгээний оноонуудын корреляци

нийт эшлэгдсэн тооноос гадна тэдгээр эшлэл нь нэр хүндтэй сэтгүүлүүдийнх байвал өндөр оноо өгдөг бөгөөд *EFS*, *AIS*-тэй төстэй. Энэ оноог ашиглан шинжлэх ухааны бүх салбаруудыг харьцуулах боломжтой гэдэг.

Bollen *et al.* (2009) *EFS*, *AIS* нь аливаа өгүүллийг эшлэж байгаа бусад өгүүлүүдийн ач холбогдол, нэр хүндийг тооцоололд оруулж буйгаараа *IF*-оос илүү сайн үзүүлэлт хэмээн дүгнэсэн байдаг нь эдийн засгийн салбарын сэтгүүлүүдийн хувьд ч мөн үндэслэлтэй байж болохыг Хавсралт-1-ээс харж болно. Жишээ нь, топ-5 сэтгүүлд ордог *Econometrica* сэтгүүл *IF*-оор 30-д эрэмбэлэгдэж байхад *EFS*-оор 7-д, *AIS*-аар 3-т байна. Эдийн засагчдын топ-сэтгүүлүүдэд дээр дурдагдсан “номын сан зүйн” оноонууд үнэхээр өндөр оноо ногдуулж байгаа эсэхийг Хүснэгт 3-т харуулж байна. Хоорондоо 95%-ийн корреляцтай *AIS*, *SJR* нь топ сэтгүүлүүдтэй хамгийн өндөр буюу 70%-ийн корреляцтай байгаа учир тэднийг илүү төлөөлөх чадвартай байна. Харин МУИС (2014)-д сэтгүүлүүдийг *IF*-аар дунджаас дээш, доош гэж 2 л хуваан үнэлдэг бөгөөд *IF* нь топ сэтгүүлүүдтэй тун бага корреляцтай байгаа нь судалгааны үнэлгээгээ илүү бодитой болгох шаардлагатай байгааг харуулж байна.

Cribari-Neto *et al.* (1999), Lubrano *et al.* (2003) нар орчин үеийн шинжлэх ухааны хөгжил нь хамтын ажиллагааг шаардаж байгаа үед  $a(p) = n$  байж болохгүй, ингэх нь мөн хамтрагч олоход хэцүү жижигхэн байгууллагуудыг илүү торгоно, нөгөө талаас оролцогчдын тоог заавал харгалзах ёстой гэсэн үндэслэлүүдээр  $a(p) = \sqrt{n}$  гэсэн байдаг. Харин МУИС (2014)-ийн журмаар оноог 1-р зохиогчид бүтнээр, холбоо барих болон бусад зохиогч бол 0.8, 0.5-аар тус бүр үржүүлж олгодог. МУИС-ийн энэхүү жинлэлт нь материалын дээж, өгөгдөл цуглуулж өгөөд л зохиогчдынх нь нэг болчихдог хэмээн сэжиглэгддэг, хэт олон зохиогчтой өгүүлүүдийг хэтрүүлж үнэлэхээс сэргийлсэн гэхээс өөр учир шалтгаангүй мэт. Мөн энэ нь цагаан толгойн үсгийн дарааллаар нэрсийн дарааллыг нь тогтоодог уламжлал харьцангуй түгээмэл эдийн засгийн салбар, дангаар болон харьцангуй цөөн хамтран зохиогчидтой нийтлүүлсэн өгүүллийг торгох сул талтай.

Хамрагдах эрдэмтдийн олонлогийг гарал үүслийг нь үл харгалзан хаана ажиллаж байгаагаар нь, эсвэл хаана ажиллаж байгааг нь үл харгалзан гарал үүсэлд нь тулгуурлах гэсэн хоёр стратегиар бүрдүүлдэг. Эхнийхийг нь *IDEAS* баримталдаг. Хүмүүн капитал, боловсон хүчин дутагдалтай, тархины гадагшлах урсгал (brain drain) өндөртэй Украины эдийн засагчдын хувьд Mirucki (1999), Coupe (2008), Оросын хувьд Шумилов & Балацкий (2016) хоёрдохыг нь ашигласныг би энд дагав<sup>12</sup>.

<sup>12</sup> *Web of Science*, *Scopus* гэх мэт хайлтын систем дээрх эрдэмтний хаяг гэсэн хэсэгт харъяат улсыг нь зааж болдог учир эхний төрлийн судалгаа нь хялбар. Харин эдийн засагчдын гарал үүслийг тогтоох нь харьцангуй төвөгтэй.

## 4 Өгөгдөл цуглуулалт

Өгөгдлийг эдийн засгийн сургалт, судалгааны байгууллага болон эрдэмтэн гэсэн хоёр ангиллаар цуглуулсан. Эрдэмтдийг хаанаас ямар зэрэг авснаар нь биш, судалгааны үр дүнгээр нь үнэлдэг учир эдийн засгийн докторын зэрэггүй ч дээрх сэтгүүлүүдэд бүтээлээ нийтлүүлдэг судлаачдыг хамруулахыг зорьлоо. Юуны өмнө Эрдэнэбат (2020а,б)-ын цуглуулсан 1945-2020 онуудад нийт 21 улсад хамгаалсан эдийн засгийн докторын 580 диссертацийн санг ашиглав. Энд боловсролын болон шинжлэх ухааны гэсэн 2 эдийн засгийн докторын зэрэгтэй 50, эхнийх нь эдийн засгийн бус, харин 2 дахь нь эдийн засгийн шинжлэх ухааны доктор гэсэн 4, эхний докторын зэргийг алгасч шууд шинжлэх ухааны докторын зэрэг хүртсэн 1, монголын боловсролын доктор хүртсэний дараа барууны доктор нэмж хүртсэн 1 хүн, угаасаа 1 докторын зэрэгтэй 473 хүний мэдээлэл бий. Мөн докторын зэрэггүй ч *WoS*, *Scopus*-ын эдийн засгийн сэтгүүлд бүтээлээ нийтлүүлсэн 30 хүн, эдийн засгийн дээд боловсролын байгууллага, нэгжид ажиллаж буй, цахим хуудсанд нь бүртгэлтэй бусад 179 багш, *RePec*-т мэргэжлийн эдийн засагч гэж бүртгүүлсэн бусад 11 хүн, нийт 751 хүнийг энэ судалгаанд хамруулав.

Байгууллагын хувьд хэдийгээр *IDEAS*-ийн жишгээр Үндэсний хөгжлийн газар, Санхүүгийн зохицуулах хороо гэх мэт төрийн эдийн засгийн мэргэжлийн байгууллагууд болон Шинжлэх ухааны академи, Үндэсний хөгжлийн хүрээлэн, Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн, Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэн, Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн, Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв гэх мэт эдийн засгийн тинк-танк, судалгааны төвүүд хамрагдах ёстой ч байгууллагын түвшний мэдээлэл нь хангалттай олдоогүй учир хамруулаагүй. Мөн Монгол улсын төрийн худалдан авах ажиллагааны цахим системд санхүү-эдийн засгаар зөвлөх үйлчилгээ үзүүлдэг сертификатын 546 эзэмшигч бий ч мэдээллүүд нь бүр олдоогүй<sup>27</sup>.

Энд БШУЯ-аас эдийн засгийн бакалавр болон түүнээс дээш зэрэг олгох зөвшөөрөл олгосон 34 их, дээд сургууль, мөн эдийн засгийн зэрэг олгодоггүй ч эдийн засгийн тэнхим, нэгжтэй сургуулиуд нэн чухал ач холбогдолтой бөгөөд эдгээрийг Хүснэт 4-т танилцуулж байна. 3-р баганад тухайн нэгжийн нийт багшийн, 4-5-р баганад тэднээс докторын зэрэгтэй болон эдийн засгийн, эдийн засагтай хавсарга докторын зэрэгтэй багш нарын, сүүлийн хоёр баганад профессор, дэд профессорын зэрэглэлд ажиллаж буй багшийн тоог харуулж байна<sup>28</sup>.

<sup>13</sup> <http://dep.num.edu.mn/econ>

<sup>14</sup> <http://sirpa.num.edu.mn>

<sup>15</sup> <http://www.sbh.edu.mn/mn/index.php/workers/cat/11>

<sup>16</sup> <http://www.sbh.edu.mn/mn/index.php/content/read/17>

<sup>17</sup> <http://seb.muls.edu.mn>

<sup>18</sup> <http://www.naog.gov.mn/staff>

<sup>19</sup> <https://www.mnums.edu.mn/tenhim.php?post=77&lang=mn>

<sup>20</sup> <https://www.ufe.edu.mn>

<sup>21</sup> <https://www.humanities.mn/page/3664>

<sup>22</sup> <http://mandakh.edu.mn/tankhim/70>

<sup>23</sup> <https://www.otgontenger.edu.mn/mn/branch/economic-and-business>

<sup>24</sup> <http://www.uberdem.edu.mn/news/single/144>

<sup>25</sup> <http://www.dalaivan.edu.mn>

<sup>26</sup> <https://www.soyolerdem.edu.mn>

<sup>27</sup> <https://www.tender.gov.mn/mn/exam/>

<sup>28</sup> Өндөр хөгжилтэй улсуудад ашигладаг *tenure track system*-ийн “жинхлэх” тогтолцоог МУИС цолтойгоо дүйцүүлдэг бөгөөд цолны хангалттай мэдээлэл олдоогүй учир энд албан тушаалын зэрэглэлийг ашиглав.

## Хүснэгт 4. Эдийн засгийн дээд боловсролын хөтөлбөртэй сургуулиуд

Нэр	багш	доктор нийт	эз-ийн	Проф. /Дэд проф.
МУИС*				
1 Эдийн засгийн тэнхим <sup>13</sup>	31	21	17	5/16
2 Олон улсын харилцааны тэнхим <sup>14</sup>	16	10	2	1/6
ШУТИС*				
3 Бизнесийн удирдлагын салбар <sup>15</sup>	29	8	2	1/4
4 Бизнесийн ахисан түвшний сургууль <sup>16</sup>	18	18	4	8/5
Хөдөө аж ахуйн их сургууль <sup>17</sup> .*				
5 Эдийн засгийн статистик, математик загварчлалын тэнхим	16	-	3	-/-
6 Хөдөө аж ахуй, хэрэглээний эдийн засгийн тэнхим	27	14	5	2/4
Удирдлагын академи				
7 Эдийн засаг, санхүүгийн удирдлагын тэнхим <sup>18</sup>	8	4	2	0/3
Анагаахын шинжлэх ухааны УИС				
8 Эрүүл мэндийн бодлогын тэнхим <sup>19</sup>	9	4	0	0/0
9 Улаанбаатарын их сургууль	-	-	-	-/-
10 Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль	-	-	-	-/-
11 Үндэсний батлан хамгаалахын их сургууль	-	-	-	-/-
12 Монгол улсын боловсролын их сургууль*	-	-	-	-/-
13 Дотоод хэргийн их сургууль	-	-	-	-/-
Төрийн өмчийн сургуулиудын дүн	154	79	35	17/38
Санхүү эдийн засгийн их сургууль				
14 Экономиксийн тэнхим <sup>20</sup>	8	2	2	2/0
Хүмүүнлэгийн ухааны их сургууль				
15 Санхүү, эдийн засгийн тэнхим <sup>21</sup>	15	1	1	1/0
Мандах их сургууль				
16 Эдийн засаг, бизнесийн тэнхим <sup>22</sup>	14	6	3	3/3
Отгонтэнгэр их сургууль				
17 Эдийн засаг бизнес удирдлагын сургууль <sup>23</sup>	21	6	3	-/-
Улаанбаатар эрдэм их сургууль				
18 Эдийн засгийн онол, менежментийн тэнхим <sup>24,*</sup>	4	1	1	-/-
Далайван дээд сургууль				
19 Эдийн засаг, менежментийн тэнхим <sup>25</sup>	4	0	0	0/0
Соёл эрдэм дээд сургууль				
20 Мэргэжлийн тэнхим <sup>26</sup>	4	0	0	0/0
21 Монголын үндэсний их сургууль	-	-	-	-/-
22 Этүгэн их сургууль	-	-	-	-/-
23 Олон улсын Улаанбаатарын их сургууль	-	-	-	-/-
24 Орхон их сургууль	-	-	-	-/-
25 Сан их сургууль	-	-	-	-/-
26 Их засаг олон улсын их сургууль	-	-	-	-/-
27 Эдийн засгийн үндэсний дээд сургууль	-	-	-	-/-
28 Чингис хаан дээд сургууль	-	-	-	-/-
29 Билиг дээд сургууль	-	-	-	-/-
30 Олон улс судлалын дээд сургууль	-	-	-	-/-
31 Шинэ иргэншил дээд сургууль	-	-	-	-/-
32 Түшээ дээд сургууль	-	-	-	-/-
33 Газарчин дээд сургууль	-	-	-	-/-
34 Маргад дээд сургууль	-	-	-	-/-
35 Олон улсын эдийн засаг, бизнесийн дээд сургууль	-	-	-	-/-
36 Хөдөлмөр, нийгмийн харилцааны дээд сургууль	-	-	-	-/-
37 Эко-Ази дээд сургууль	-	-	-	-/-
Төрийн бус өмчийн сургуулиудын дүн	70	16	10	6/3
Нийт	224	95	45	23/41

Хангалттай мэдээлэл байхгүй бол “-”-ээр, эдийн засгийн докторын хөтөлбөртэй байсан эсвэл/бөгөөд одоо ч байгаа бол \*-оор тэмдэглэв. Эх үүсвэр: Дээд боловсролын салбарын 2018-2019 оны хичээлийн жилийн статистик. БШУЯ.

Олон улсын жишгээр их сургуулийн багшид тухайн салбараар нэр хүнд бүхий эрдэм шинжилгээний сэтгүүлд нийтлүүлсэн бүтээлүүдтэй, эсвэл докторын зэргийг нь хүртсэн болон хүртэхэд тун ойр байх үндсэн шаардлага тавигддаг. Эдийн засгийн тэнхимийн дундаж хэмжээний хувьд Madden, Savage & Kemp (1997) Австралийн тэргүүлэх 29 тэнхим 21 багш, Ben-David (2010) Израйлынх 22 багштай байгааг дурдсан байдаг. Гэтэл Хүснэгт 4-өөс эдийн засгийн хөтөлбөртэй төрийн болон хувийн өмчийн их сургуулиудын нийт багш нарын 22.7% болон 14.3% нь л тус бүр эдийн засгийн докторын зэрэгтэй байгаа нь, үлдэх хэсэг нь өндөр түвшний бүтээлтэй хүмүүс биш л бол, энэхүү суурь шаардлага, жишгийг хангасан багш нар, нөөц бололцоо Монгол улсын дээд боловсролын байгууллагаар хэт тарж бутарсан, ууссан байдалтай байгааг харж болно. МУИС-ийн хувьд хэдий 2014 оны бүтцийн өөрчлөлтөөр нэг шинжлэх ухааны салбарыг нэг нэгжид хариуцуулах зорилготой байсан гэх ч эдийн засгийн хичээлийг 2 нэгжээс орж, МУИС-ийн захиргаа Бээжингийн их сургуулийн Эдийн засгийн сургуультай хамтран ажиллах гэрээг Эдийн засгийн тэнхим бус, харьцангуй цөөн эрдэмтэдтэй Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуультай 2019.06.17-нд байгуулсан нь үүний нэг ойрын жишээ юм.

Мөн хүснэгтээс төрийн өмчийн их сургуулиудын хувьд нийт багш нарын 35.7% нь профессор, дэд профессор гэсэн шинжлэх ухааны дээд албан тушаалуудыг хашиж байхад хувийн секторт эдгээр нь маш бага, 12.8% байгаа нь мэргэжлийн удирдлагаар хангах боловсон хүчин нэг бол хувийн сургуулиудад дутагдаж буйн, үгүй бол төрийн өмчийн сургуулиудад хэт ихэдсэний илрэл байж болно. Зохих мэргэжлийн удирдлага дор нэгдсэн, чадварлаг боловсон хүчин бүрдсэн цагт л багш нар нь нэг зорилготойгоор хамтран ажиллах, бие биенээсээ суралцан хөгжих, нөлөөлөх (peer-pressure), өрсөлдөх орчин бүрдэж, оюутнуудаар нь дамжин шинжлэх ухаан нийгэмд түгдэг.

Мэргэжлийн чиг баримжаа, удирдлагаа тогтоохдоо 70 гаруй жилийн социалист түүхээ бид бодолцох ёстой. Өмнөх тогтолцооны үед орчин үеийн эдийн засгийн шинжлэх ухаан Монголд нэвтрээгүй байх гэсэн үндэслэлээр 1993 оноос өмнө докторын зэрэг хамгаалсан 300 орчим хүнийг түүвэрт оруулах шаардлагагүй мэт санагдаж болох юм. Гэвч Н.Д.Кондратеев, Е.Е. Слуцкий, Л.В.Канторович, В.М.Полторович, В.И.Данилов, А.И.Слоцков, М.В.Попов гэх мэт ЗХУ-ын эдийн засагчид тэргүүлэх сэтгүүлүүдэд бүтээлээ амжилттай нийтлүүлдэг байсан учир монголчууд ч тэдний шавь байсан байхыг үгүйсгэх аргагүй билээ (Campbell, 2012). Мөн социалист байсан улсуудын болон социалист систем, сэтгэлгээнд илүү ойр барууны эрдэм шинжилгээний сэтгүүлүүд ч, жишээ нь *Post-Soviet Affairs*, *Economic Systems Research*, *Socio-Economic Planning Sciences*, *Europe-Asia Studies*, *Economic Systems*, *Economics of Transition*, *Economic Research- Ekonomika Istraživanja*, *Baltic Journal of Economics*, *Post-Communist Economies*, *Eastern European Economics*, *Agricultural Economics-Zemledelska Ekonomika*, *Prague Economic Papers*, *E & M Ekonomika a Management*, *Romanian Journal of Economic Forecasting*, *Ekonomický časopis*, *Politická ekonomie*, *Journal of Comparative Economics*, *Actuel Marx* дээрх библиометрийн сангуудад байгааг дурдах нь зүйтэй юм. Иймд олонлог маань IDEAS-ын зарчмын дагуу, зөвхөн одоо идэвхтэй ажиллаж буй болон амьд сэрүүн байгаа эрдэмтдээр хязгаарлагдаагүй бөгөөд 2020 оны 10-р сар хүртэлх хугацааг хамарна.

## 5 Үр дүн

Энэ хэсэгт эхлээд эрэмбэ тогтооход ашиглагдах монголчуудын бүтээлээ нийтлүүлсэн сэтгүүлүүдийн олонлогийг танилцуулж, дараа нь монгол эдийн засагчид, монгол дахь эдийн засгийн сургалт, судалгааны байгууллагуудын чансааг тогтооно. Өнөөгийн нөхцөл байдлыг сайжруулахад юуг анхаарч болох талаар саналаа мөн түсгав.

Хүснэгт 5. Монголчуудын нийтлүүлсэн топ, *WoS*, *Scopus*-ийн сэтгүүлүүд

Сэтгүүлийн нэр	Тоо	Сэтгүүлийн нэр	Тоо
<b>ТОП-5</b>		Econometric Reviews	1
Econometrica	1	Economic Theory	1
<b>ТОП-8</b>		Experimental Economics	1
Journal of Economic Theory	2	Hitotsubashi Journal of Economics	1
Review of Economics and Statistics	1	International Journal of Game Theory	1
<b>ТОП-35</b>		Journal of Environmental Econ. and Manag.	1
Games and Economic Behavior	4	Journal of Korea Trade	1
Journal of Economic Dynamics & Control	4	Journal of Risk and Insurance	1
World Bank Economic Review	4	Manchester School	1
Journal of Applied Econometrics	3	Oxford Bulletin of Economics and Statistics	1
Journal of Economic Behavior & Organization	3	Oxford Economic Papers	1
Economics Letters	3	Series	1
European Economic Review	2	Small Business Economics	1
Journal of Econometrics	2	Southern Economic Journal	1
Journal of Monetary Economics	2	Structural Change and Economic Dynamics	1
Economic Journal	1	<b>Зөвхөн <i>WoS</i>-371</b>	
Journal of Economic Growth	1	Mathematical Social Sciences	4
Journal of Money Credit and Banking	1	Energy Policy	3
Journal of Public Economics	1	Journal of Development Studies	2
<b><i>WoS</i>-371 <math>\cap</math> <i>Scopus</i>-997</b>		Economist-Netherlands	1
Journal of Banking & Finance	5	Review of International Economics	1
Journal of Mathematical Economics	4	Tourism Economics	1
Resource and Energy Economics	4	Transportation Research Part A	1
World Development	4	<b>Зөвхөн <i>Scopus</i>-997</b>	
World Economy	4	Central Bank Review	5
American Economic Journal-Microeconomics	3	Economics Bulletin	5
Economic Modelling	3	International Economic Journal	3
Post-Communist Economies	3	Advances in Econometrics	2
American Journal of Agricultural Economics	2	Agricultural and Resource Economics Review	2
China Economic Review	2	Entrepreneurship and Regional Development	2
Economic Analysis and Policy	2	Global Finance Journal	2
Economic Inquiry	2	Harvard Business Review	1
Economica	2	International Economics	2
Energy Economics	2	International Journal of Entrepreneurship and	1
		Innovation Management	
Environment and Development Economics	2	Journal of Agricultural and Applied Economics	2
Journal of World Trade	2	Journal of International Business Studies	1
Social Choice and Welfare	2	Pacific Basin Finance Journal	2
Agricultural Economics	1	Agricultural and Food Economics	1
American Economic Journal-Economic Policy	1	World Customs Journal	2
Annals of Economics and Finance	1	Economic Papers	1
World Trade Review	2	Economies	1
Annals of Public and Cooperative Economics	1	Financial Management	1
Applied Economic Perspectives and Policy	1	Financial Markets, Institutions and	1
		Instruments	
Applied Economics	1	Industrial and Corporate Change	1
Applied Economics Letters	1	International Journal of Finance and	1
		Economics	
Australian Economic Papers	1	Journal of Business Ethics	1
Bulletin of Economic Research	1	Journal of Corporate Finance	1
Climate Change Economics	1	Research in Experimental Economics	1
Developing Economies	1	Risk and Decision Analysis	1
Ecological Economics	1	Strategic Entrepreneurship Journal	1

Монголчуудаас нийтлүүлсэн сэтгүүлүүдийн нэр, тэдгээрт хэдэн удаа хэвлүүлснийг тайлагнаж байна. Монголчууд хоорондоо хамтарсан бол тус бүрт нь тоолов. Топ-5, топ-8, топ-35, *WoS*-371, *Scopus*-997 сэтгүүлийн аль алинд ордог (топ сэтгүүлүүд энд бүгд багтсан), зөвхөн *WoS*, зөвхөн *Scopus*-ынх гэж бүлэглэв.



Монгол эдийн засагчдын нийтлүүлсэн *Scopus*, *WoS*-ийн оноотой 89 сэтгүүлийн нэр, давтамжийг Хүснэгт 5-д харуулж байна<sup>29</sup>. Монгол улсын түүхэнд монголчууд дангаар болон бусадтай хамтран топ-5-д нэг, топ-8-ын гурван сэтгүүлд дөрөв, топ-35-ын 16 сэтгүүлд 35 удаа бүтээлээ нийтлүүлжээ. Монголчуудын хамгийн их хэвлүүлсэн сэтгүүл нь тус бүр 5 монгол нийтлүүлсэн *Scopus*-ын *Central Bank Review*, *Economics Bulletin*, *WoS*, *Scopus*-ын аль алинд нь ордог *Journal of Banking & Finance* ажээ.

29 монгол *WoS*-ийн эдийн засгийн 371 сэтгүүлээс 67-д нь, 56 монгол *Scopus*-ын эдийн засаг-эконометрик, эдийн засаг-экономтерик-санхүү (янз бүрийн), ерөнхий эдийн засаг-эконометрик-санхүү гэсэн 3 ангилалд харгалзах 997 сэтгүүлээс 84-д нь, 64 монгол *WoS*, *Scopus*-ын нийлсэн 1057 сэтгүүлээс 94-д нь нийтлүүлжээ. Эдгээр хүмүүс судалгаанд хамрагдсан 751 хүний нэн бага буюу 8.6%-ийг бүрдүүлж байна. Эдийн засгийн 530 докторын хувьд ердөө 6.6% л *WoS*, *Scopus*-ын бүтээлтэй байгаа нь удиртгалд дурдсан урд хөршийн шинэ стандартаар зэргийнх нь 93%-аас дээш нь хүчингүй гэсэн үг юм.

Эдийн засагчдын *Scopus*, *WoS*-т бүртгэлтэй өгүүллийн тоогоорх эрэмбийг Хүснэгт 6-д харуулж байна. 3-р баганад *Google Scholar* дахь эшлэлийн тоо болон *h/i10* оноог, 4-р баганад топ- 5, 8, 35, *WoS*, *Scopus*-ын эдийн засгийн сэтгүүлд нийтүүлсэн нийт өгүүллийн тоог, одоогийн харъяаллыг нь 5-р баганад, эдийн засгийн докторын зэргээ хаанаас хүртсэн (үгүй бол хоосон) мэдээллийг сүүлийн баганад харуулж байна<sup>30</sup>. Энд 35 буюу 54% нь эмэгтэйчүүд, 27 буюу 43% нь гадаадад амьдардаг, 39 буюу 60% нь их сургуульд ажиллаж, сурдаг хүмүүс байна.

*GS*-ын хувьд 5-аас 3023 эшлэлтэй 20 хүн л хамрагдсан, мөн үндсэн мэргэшил нь эдийн засгаас өөр эрдэмтдийн эшлэл нийтдээ тайлагнагдаж буй учир хангалттай бүрэн эрэмбэлэлт хийх боломж олгоогүй. *WoS*, *Scopus*-ын сэтгүүлд бүтээлээ нийтлүүлэхэд, бүр өндөр эшлэгддэг судлаач байхад эдийн засгийн докторын зэрэг заавал шаардлагагүйг уг хүснэгтэд байгаа хүмүүсийн бараг тал хувь нь, топ-10-аас 3 нь эдийн засгийн докторын зэрэггүй хүмүүс байгаагаас харж болно. Нөгөө талаас олон улсын жишгээр докторын сургалтын үндсэн зорилго нь эдгээр сэтгүүлд бүтээлээ нийтлүүлэх ур чадвар олгоход чиглэдэг тул энэ нь монголчуудын хамрагдаж буй сургалтын чанарт өгч буй муу дүн байж болох юм.

*WoS*, *Scopus*-ын сэтгүүлд нийтлүүлсэн тоонд тулгуурлан эрдэмтдийг эрэмбэлэх нь 64 хүнийг ердөө 24 байр эзлүүлэхэд хүргэж байгаагаараа учир дутагдалтай байна. Мөн хэдийгээр эдгээр сэтгүүл *WoS*, *Scopus*-ын босгыг давсан ч дотроо чанарын асар их ялгаатай. Жишээ нь, Хавсралт 1-ээс топ-5-ын нэг болох, 1886 онд үүссэн эдийн засгийн анхны сэтгүүл болох *Quarterly Journal of Economics*-ийн *AIS* (*CiteScore*, *IF*) оноо нь хамгийн бага оноотойгийнхоос даруй 1163 (227, 79) дахин өндөр, монголчуудын нийтлүүлсэн хамгийн топ сэтгүүл болох *Econometrica*-ийнх хамгийн доод оноотой сэтгүүл болох *Journal of Korea Trade*-ынхаас 519 (13.5, 6.2) дахин өндөр байгаа нь спорттой зүйрлэвэл Олимпын амжилтыг сум, багийнхтай жишихтэй агаар нэг юм. Энэ нь МУИС-аас *WoS*-ийн сэтгүүлд нийтлүүлсэн судлаачдаа урамшуулахдаа чанарыг биш, тоог эрхэмлэж байгаагаасаа татгалзах, чанарын үзүүлэлтүүдийг түлхүү ашиглах ёстойг харуулж байна.

<sup>29</sup> Тодорхой нэг сэтгүүлд монголчууд хамтран нийтлүүлсэн бол тус бүрд нь тоолов.

<sup>30</sup> Өмнө дурдсанчлан эдийн засгийн мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлсэн л бол “эдийн засагч” хэмээн нэрлэж байгаа. Тухайлбал эдийн засгийн докторын зэрэггүй боловч энд орсон санхүүгийн доктор-3, бэлчээрийн экосистемийн доктор-2, анагаах ухааны доктор-2, бизнесийн удирдлагын доктор-1, байгаль орчны менежмент ба хөгжлийн доктор-1, нийгмийн антропологи доктор-1, цөмийн инженерчлэлийн доктор-1, хөдөө аж ахуйн доктор-1, улс төр судлалын доктор-1, эдийн засгийн докторын оюутан-5, нийтийн бодлогын магистр-3, эдийн засгийн магистр-2, олон улсын харилцааны магистр-2, бусад нь эдийн засгийн бакалавр зэрэгтэй хүн байна.

Хүснэгт 6. Эдийн засагчдын чансаа (*Scopus*, *WoS*-ийн тоогоор)

#	Нэр	Google S. эшлэл/h10	Өгүүллийн тоо T5 T8 T35WoS Scopus					Ажиллаж, сурч буй сургууль, байгууллага	Э.з.-ийн докторын зэрэг
1	Т. Норовсамбуу	167 6/5	0	1	5	11	11	Далхаус, Канад	Браун, АНУ
2	Ч. Төгсжаргал		0	0	1	6	9	Лоёола, АНУ	
3	И. Ариун	248 9/8	0	0	0	3	9	Техас A&M, АНУ	Йова муж, АНУ
4	Д. Лхагвасүрэн	314 8/7	0	0	7	7	7	Конкордиа, Канад	Рочестер, АНУ
5	Г. Рагчаасүрэн		0	0	3	6	6	Гэрэгэ парт. ХХК. Монгол	Манчестер, Англи
5	Б. Эрдэнэбат	152 6/5	0	1	1	6	6	МУИС, Э.з.-ийн тэнхим	Манчестер, Англи
7	Д. Ган-Очир		0	0	0	3	6	Монголбанк	Авсралийн УИС
7	Э. Отгонцэцэг	514 8/7	0	0	0	3	6	Бентлей, АНУ	
9	Б. Батжаргал	302316/20	0	0	0	0	6	Оклахома муж, АНУ	
10	Ц. Гэрэлт	140 6/3	0	1	2	6	5	Виржиниа Тех. АНУ	Калифорния Тех. АНУ
11	Г. Батшүр	751 10/10	0	0	1	5	5	Дэлхийн банк, АНУ	
12	Н. Өнөржаргал	54 4/2	0	0	0	3	5	Нью Йорк хот тех. АНУ	Нийгмийн С.Ш.С. АНУ
12	Н. Ууганбаатар	26 3/0	0	0	1	3	5	МУИС, Математикийн тэнхим	Стокхолм, Швед
14	Б. Монголжин	30 3/1	0	0	2	4	4	Жоржтаун, Катар	Браун, АНУ
15	Т. Пүрэвдорж		0	0	2	3	4	Йорк, Канад	МкГилл, Канад
16	Т. Билигбаатар		0	0	1	3	3	Шанхай СЭЗИС, Хятад	Нью Йорк муж, АНУ
16	Д. Оюунбадам		0	0	0	3	3	Нээлттэй НХ. Монгол	Чарлес Стьюрт, Австрали
18	Лу.Даваажаргал		0	0	1	1	3	Монголбанк	Авсралийн УИС
18	Д. Долгорсүрэн		0	0	0	1	3	Удирдлагын академи, Монгол	Хавай, АНУ
20	Т. Болормаа		0	0	0	3	2	НУБ, Швейцар	Лузан, Швейцар
21	Б. Алтанцэцэг		0	0	1	2	2	МУИС, Э.з.-ийн тэнхим	Виржиниа, АНУ
21	Т. Уянга	36 2/2	0	0	1	2	2	Иесег, Франц	Эрасмус, Нидерланд
21	П. Авралт-Од	59 3/2	0	0	0	2	2	Корнелл, АНУ	
21	А. Бакей		0	0	0	2	2	ШУА	ШУА, Монгол
25	Б. Хүслэн		0	0	1	1	2	Монголбанк	
26	Г. Цогбадрал		1	1	1	3	1	Райерсон, Канад	Жонс Хопкинс, АНУ
27	Б. Цэндсүрэн		0	0	0	2	1	Авсралийн УИС, Австрали	
28	Д. Баярмаа		0	0	1	1	1	Нью Хампшер, АНУ	
28	А. Гантунгалаг		0	0	1	1	1	МУИС, Э.з.-ийн тэнхим	Манчестер, Англи
28	Б. Соёлмаа	13 2/0	0	0	1	1	1	МУИС, Э.з.-ийн тэнхим	Манчестер, Англи
28	Т. Ариунаа	44 3/3	0	0	0	1	1	Минисотта, АНУ	Окклохама муж, АНУ
28	Б. Байвал		0	0	0	1	1	Нутаг партнерс, ХХК, Монгол	
28	Б. Батжав		0	0	0	1	1	ШУА, Геологи Х. Монгол	
28	Т. Баярсайхан		0	0	0	1	1	Дэлхийн банк, АНУ	Нью Ингланд, Австрали
28	Ж. Болормаа	10 2/0	0	0	0	1	1	Капитал 1, АНУ	Минисотта, АНУ
28	Б. Бурмаажав		0	0	0	1	1	Анагаах У.Х. Монгол	
28	Ц. Гантөмөр		0	0	0	1	1	Вик консалт, Герман	ЭЗХ, Герман
28	Д. Кадирбек		0	0	0	1	1	ХААИС	
28	С. Лодойсамба		0	0	0	1	1	Герман Монголын сургууль	
28	Х. Онон		0	0	0	1	1	Инвест Монголиа	
28	Д. Өлзийжаргал		0	0	0	1	1	Хаан банк	
28	Б. Пүрэв		0	0	0	1	1	ХААИС	ХААИС
28	Б. Сувд		0	0	0	1	1	Эрүүл мэндийн яам, Монгол	
28	Б. Түвшинтөгс		0	0	0	1	1	МУИС, Э.з.-ийн тэнхим	Бостон, АНУ
28	Б. Түмэннасан		0	0	0	1	1	Бентлей, АНУ	Жеоржиа муж, АНУ
28	У. Тунгалаг	163 4/2	0	0	0	1	1	Саруул хөдөө ТББ	
28	С. Ундаргаа		0	0	0	1	1	Авсралийн УИС, Австрали	
28	Б. Цолмон		0	0	0	1	1	ЭЗХ (ERI), Монгол	
28	Ц. Цэрэндаваа		0	0	0	1	1	ХААИС	
28	Т. Эрдэнэчулуун	67 3/3	0	0	0	1	1	ХААИС	
28	А. Энхжаргал		0	0	0	1	1	Эрүүл мэндийн яам, Монгол	
52	Н. Батнасан	5 1/0	0	0	0	0	1	МУИС, Бизнесийн сургууль	МУИС
52	Лх.Даваажаргал		0	0	0	0	1	Сангийн Яам	Хятадын ШУА
52	Г. Мөнхбаяр		0	0	0	0	1	Монголбанк	
52	Б. Мөнх-Өлзий	44 4/2	0	0	0	0	1	МУИС, Олон улсын харилцаа	
52	Б. Ундрал		0	0	0	0	1	Монголбанк	
52	Б. Хулан		0	0	0	0	1	Монголбанк	
52	Д. Цэндсүрэн		0	0	0	0	1	Гаалийн ерөнхий газар	
52	Ч. Энхбаяр		0	0	0	0	1	МУИС, Бизнесийн сургууль	Байгалийн УИС
52	Д. Энхзаяа		0	0	0	0	1	Монголбанк	
61	Н. Батсайхан		0	0	0	2	0	Монхорус, ХХК. Монгол	Тринити, Ирланд
62	Б. Айгерим		0	0	0	1	0	Франкфурт С.Э.з., Герман	
62	С.Дэлгэржаргал		0	0	0	1	0	Ветемнет, ХХК, Монгол	
62	Д. Ринчиндорж		0	0	0	1	0	ХААИС	
62	А. Хулан		0	0	0	1	0	Тилбург, Недерланд	Тилбург, Недерланд

3-р баганад *Google Scholar*, *GS* дахь эшлэлийн тоо болон *h/i10* оноог (2020.10.22-ны байдлаар. *GS*-ын дансгүй бол хоосон), дараа нь топ-5, топ-8, топ-35 болон *WoS*, *Scopus*-ын сэтгүүлд нийтлүүлсэн тоог (хуримтлуулсан), сүүлийн хоёр баганад одоогийн харьяалал болон эдийн засгийн докторын зэргээ хаанаас хүртсэн (үгүй бол хоосон) мэдээллийг харуулж байна. Эрэмбэлэхдээ хамгийн олон хүн хамрагдах боломжтой учир *Scopus*-ыг, тэнцсэн тохиолдолд *WoS*-ийг ашиглав.



Хүснэгт 7-д эрдэмтдийн *AIS*, *EFS*, *IF*, *CiteScore*, *SNIP*, *SJR* оноонуудыг Cribari-Neto *et al.* (1999)-ын  $\sqrt{n}$  болон МУИС-ийн жинтэйгээр тайлагнаж,  $AIS_{\sqrt{n}}$ -аар, тэнцсэн тохиолдолд  $CiteScore_{\sqrt{n}}$ -оор эрэмбэлэв. Хүснэгт 6-д эдийн засгийн топ сэтгүүлд нийтлүүлснээр эрэмбэлэх нь *WoS*, *Scopus*-д нийтлүүлсэн тоогоорх эрэмбээс эрс ялгаатай байсны нэгэн адил библиометрийнхээс ч нэлээд ялгаатай, ялангуяа  $\sqrt{n}$  жин нь МУИС-ийнхаас нэлээд ялгаатай үр дүнд хүргэж болохыг эндээс харж болно. Энд эрэмбэ нь судалгааны ажлын чанараас гадна мөн сэдвээс хамаарч байгааг цохон тэмдэглэх хэрэгтэй. Тодруулбал Монголын эдийн засгийн талаарх, Монголтой илүү холбоотой сэдвүүд нь Дэлхийн эдийн засгийн шинжлэх ухааны топ сэтгүүлүүдэд нийтлэгдэх магадлал нь харьцангуй бага учир тийм судлаачдын эрэмбэ нь доогуур байх талтай.

Мөн *AIS* нь *IF*-ыг бодвол судалгааны үр дүнд тулгуурладаг хөдөлмөрийн зах зээлийн үнэлгээ болох шинжлэх ухааны албан тушаалтай илүү хамааралтай байна. Тухайлбал *IF*-оор тооцвол монголын дэд профессорын цолтоны (Б.Эрдэнэбат) оноо нь өндөр хөгжилтэй улсуудад төрсөн эдийн засгийн *tenured* буюу жинхэлсэн профессор (Т.Норовсамбуу), дэд профессор (Д.Лхагвасүрэн, И.Ариун)-ынхоос дунджаар өндөр болчихоор байна. Энэ нь МУИС (2014)-ийн журмыг *IF*-оос *AIS*-руу шилжүүлэх шаардлагатай өөр нэг баримт юм.

Дээрх хоёр хүснэгтэд Цэвээн (2012)-д намтрыг нь алдаршуулсан 44 шинжлэх ухааны доктор, Эрдэнэбат (2020б)-д буй ЗХУ болон ОХУ-ын докторын дээд зэрэг болох *Доктор экономических наук (ДЭН)*-тай 36 хүнээс ганц нь ч, эдийн засгийн профессор цолтонгууд, дотоодын дээд зэрэг болох шинжлэх ухааны доктор (*ScD*) 18 хүн, эдийн засгийн салбараарх Монгол Улсын ШУА-ийн 7 академичаас ганцаас бусад нь, Хүснэгт 4 дэх 23 профессороос 2-оос бусад нь, 41 дэд профессороос 4-аас бусад нь төлөөлөлгүй байна.

Иймд эдийн засгийн профессор, дэд профессорын цол, зэрэглэлийг олон улсын жишигт ойртуулан нэгтгэж, тэдний болон академичийн ажлын байрны тодорхойлолтод нь *WoS*, *Scopus*-ын оноо бүхий дор хаяж нэг өгүүлэлтэй байхыг шаардаж, шаардлага хангаагүйг нь зогсоон, цуцлахгүй л бол орчин үеийн шинжлэх ухааныг Монголд нэвтрүүлэхгүй байх ашиг сонирхлын зөрчилтэй томоохон лобби бүлэг давамгайлж, цаашид ч Монголын нийгмийг шинжлэх ухаантай холбох эрдэмтэд үүсэхээргүй байна. Мөн эдийн засгийн докторын удирдагч, доктор хамгаалуулах зөвлөлийн гишүүнд тавигдах шаардлагуудад ч *WoS*, *Scopus*-ын бүтээлтэй байх ёстой гэж оруулах шаардлагатай байна.

*WoS*, *Scopus*-д нийтлүүлсэн хүмүүсийн 55% эмэгтэй байгаа нь хүйсийн тэгш байдлын талаар гаргасан Монголчуудын нэг амжилт мэт. Гэвч дээрх 19 шинжлэх ухааны доктороос (*ScD*) ганц нь ч, 36 *ДЭН*-ийн 4 нь буюу 11% нь л, шинжлэх ухааны бус, 1 эдийн засгийн докторын зэрэгтэй 474 хүний 134 буюу 28% нь л эмэгтэй байгаа. Тэгэхээр шинжлэх ухааны зэрэг, түүнтэй холбоотой цалингийн нэмэгдэл, урамшууллын дийлэнхийг эрэгтэйчүүд хүртэж байхад *WoS*, *Scopus*-ын босгыг давагсдын дийлэнх нь эмэгтэйчүүд байгаа нь ажил, урамшуулал хоёрын хооронд сөрөг хамаарлыг үүсгэж байна. Энэ нь эдийн засгийн шинжлэх ухаан гэж юу болох, докторын зэргийг яах гэж хүртдэг талаарх бидний ойлголт дэлхийн жишгээс зөрсний өөр нэг илрэл юм.

Хүснэгт 8-д эдийн засгийн салбараарх Монголын их, дээд сургуулиуд, судалгааны болон бусад байгууллагуудын чансааны жагсаалтыг харуулж байна. Мөн орчин үеийн эдийн засгийн шинжлэх ухааны мэдлэг нийгэмд хэр хүрч байгааг хэмжих зорилгоор их, дээд сургуулиудын хувьд мэдээлэл нь нийтэд нээлттэй бакалавр, магистр, докторын оюутных нь тоог 3-р баганад оруулав. Эдгээр сургуульд Монгол Улсын нийт бакалавр, магистр, докторын оюутнуудын 79.8%, 75.0%, 91.2% тус бүр суралцаж байгаа нь судалгааны дүгнэлт маань нийт дээд боловсролын салбарыг тодорхой хэмжээнд төлөөлөх чадвартай

Хүснэгт 7. Эдийн засагчдын чансаа ( $AIS$ ,  $CiteScore$  оноогоор)

#	Нэр	$\sqrt{n}$						МУИС-ийн жин					
		$AIS$	$EFS$	$IF$	$CiteScore$	$SNIP$	$SJR$	$AIS$	$EFS$	$IF$	$CiteScore$	$SNIP$	$SJR$
1	Д. Лхагвасүрэн	12.60	6.89	10.70	18.87	10.90	16.35	13.33	7.28	11.40	20.13	11.64	17.26
2	Т. Норовсамбуу	12.58	8.14	10.24	18.34	11.42	17.94	13.12	7.70	9.89	18.23	11.48	18.28
3	Г. Цогбадрал	7.92	3.12	3.68	5.73	3.43	10.30	11.28	4.45	5.33	8.10	4.85	14.56
4	Г. Рагчаасүрэн	7.54	2.53	9.05	18.95	11.04	9.66	7.83	2.48	9.36	19.71	11.43	10.00
5	Ц. Гэрэлт	7.45	5.04	5.62	9.81	6.07	9.29	7.57	5.03	5.53	9.86	6.07	9.44
6	П. Авралт-Од	5.45	1.69	4.52	8.76	3.69	6.53	4.10	1.31	3.70	7.00	2.90	4.97
7	Б. Эрдэнэбат	4.94	4.71	10.62	18.82	6.60	7.94	9.12	8.01	17.93	31.80	11.69	14.32
8	Ч. Төгсжаргал	4.78	4.54	9.58	22.71	11.17	9.53	6.57	5.99	12.34	30.68	15.40	13.60
9	Т. Пүрэвдорж	4.18	3.56	3.23	9.40	5.86	7.26	3.67	3.13	2.83	9.15	5.64	6.97
10	Б. Монголжин	3.21	2.43	3.66	6.65	3.77	4.05	3.44	2.74	3.83	6.84	3.87	4.42
11	И. Ариун	2.29	0.98	5.49	14.56	7.12	5.53	2.97	1.20	7.32	19.99	9.81	7.73
12	Т. Уянга	1.97	0.95	1.97	3.29	1.76	2.70	1.71	0.82	1.71	2.85	1.53	2.34
13	Г. Батшүр	1.67	0.63	3.49	5.88	3.37	2.09	1.94	0.81	4.47	7.46	4.38	2.38
14	Э. Отгонцэцэг	1.61	1.69	3.39	12.69	6.29	4.20	1.82	1.70	3.78	16.35	7.87	5.41
15	Т. Билигбаатар	1.59	1.04	1.58	2.31	1.63	2.03	1.81	1.17	1.76	2.88	2.02	2.39
16	Н. Батсайхан	1.49	5.55	6.48	0	0	0	2.31	8.64	10.08	0	0	0
17	Лу. Даваажаргал	1.43	0.60	1.34	4.30	2.44	2.04	2.02	0.85	1.90	6.00	3.34	2.86
18	Б. Хүслэн	1.43	0.60	1.34	3.74	2.07	1.91	1.01	0.43	0.95	2.80	1.54	1.38
19	Н. Ууганбаатар	1.28	1.86	3.20	5.70	3.17	2.22	1.28	1.86	3.20	5.70	3.17	2.22
20	С. Ундаргаа	1.03	1.75	2.74	5.02	2.04	1.57	1.46	2.48	3.87	7.10	2.88	2.22
21	Н. Өнөржаргал	0.93	1.39	4.16	9.49	4.63	2.23	1.32	1.96	5.88	13.00	6.23	3.07
22	Д. Долгорсүрэн	0.88	0.59	1.18	3.23	1.95	1.50	0.88	0.59	1.18	3.32	2.09	1.53
23	Б. Алтанцэцэг	0.80	0.16	1.02	1.66	0.88	1.00	0.98	0.19	1.28	2.00	1.10	1.18
24	Б. Батжав	0.73	1.24	1.93	3.55	1.44	1.11	1.16	1.98	3.10	5.68	2.30	1.78
24	Б. Байвал	0.73	1.24	1.93	3.55	1.44	1.11	1.16	1.98	3.10	5.68	2.30	1.78
24	У. Тунгалаг	0.73	1.24	1.93	3.55	1.44	1.11	1.16	1.98	3.10	5.68	2.30	1.78
27	Т. Болормаа	0.72	0.29	1.56	1.73	1.04	0.50	1.05	0.42	2.03	2.11	1.28	0.63
28	Б. Цэндсүрэн	0.69	1.04	3.20	1.56	0.58	0.48	0.59	0.93	3.27	2.20	0.82	0.67
29	Б. Айгерим	0.67	2.49	2.91	0	0	0	0.58	2.16	2.52	0	0	0
30	Д. Баярмаа	0.66	0.14	0.79	1.43	0.68	0.89	0.74	0.16	0.88	1.60	0.76	1.00
30	Б. Соёлмаа	0.66	0.14	0.79	1.43	0.68	0.89	0.74	0.16	0.88	1.60	0.76	1.00
32	Б. Пүрэв	0.64	1.12	2.59	3.98	1.07	0.99	0.55	0.97	2.24	3.45	0.93	0.86
33	Т. Баярсайхан	0.61	0.26	1.60	2.83	1.09	0.99	0.86	0.37	2.26	4.00	1.54	1.40
34	Ц. Гантөмөр	0.56	0.18	1.40	2.47	0.99	0.79	0.80	0.26	1.98	3.50	1.40	1.12
35	А. Бакей	0.53	0.29	1.81	2.80	1.30	0.75	0.53	0.29	1.81	2.80	1.30	0.75
36	А. Гантунгалаг	0.48	0.43	0.60	1.20	0.70	0.58	0.95	0.85	1.20	2.40	1.41	1.17
37	Б. Түмэннасан	0.46	0.68	1.01	1.70	0.87	0.60	1.04	1.52	2.27	3.80	1.94	1.34
38	С. Дэлгэржаргал	0.46	0.32	0.92	0	0	0	0.40	0.28	0.80	0	0	0
38	Д. Ринчиндамба	0.46	0.32	0.92	0	0	0	0.40	0.28	0.80	0	0	0
40	Т. Эрдэнэчулуун	0.45	0.27	1.37	2.00	0.95	0.56	0.90	0.54	2.74	4.00	1.90	1.12
41	Д. Оюунбадам	0.41	0.29	2.32	3.80	1.90	1.09	0.52	0.38	3.62	5.86	2.82	1.64
42	Б. Цолмон	0.34	0.08	0.83	1.27	0.51	0.45	0.59	0.13	1.43	2.20	0.88	0.79
43	Б. Бурмаажав	0.33	0.09	0.69	1.47	0.42	0.56	0.43	0.12	0.91	1.95	0.56	0.74
43	А. Энхжаргал	0.33	0.09	0.69	1.47	0.42	0.56	0.43	0.12	0.91	1.95	0.56	0.74
43	С. Лодойсамба	0.33	0.09	0.69	1.47	0.42	0.56	0.43	0.12	0.91	1.95	0.56	0.74
43	Б. Сувд	0.33	0.09	0.69	1.47	0.42	0.56	0.43	0.12	0.91	1.95	0.56	0.74
47	Д. Ган-Очир	0.23	0.10	2.54	7.64	3.86	1.89	0.33	0.14	3.60	10.80	5.45	2.68
48	Ж. Болормаа	0.21	0.04	0.67	0.67	0.37	0.14	0.24	0.04	0.75	0.75	0.41	0.16
49	А. Хулан	0.20	0.02	0.39	0	0	0	0.29	0.04	0.55	0	0	0
50	Б. Түвшинтөгс	0.19	0.48	0.78	1.34	0.66	0.33	0.27	0.68	1.10	1.90	0.94	0.47
51	Д. Өлзийжаргал	0.15	0.27	0.53	0.92	0.50	0.26	0.10	0.19	0.38	0.65	0.35	0.18
52	Т. Ариунаа	0.10	0.06	0.81	0.60	0.30	0.20	0.12	0.06	0.91	0.60	0.30	0.20
53	Д. Кадирбек	0.09	0.02	0.44	0.80	0.35	0.19	0.17	0.04	0.88	1.60	0.70	0.39
54	Х. Онон	0.02	0	0.44	0.42	0.12	0.10	0.02	0.00	0.50	0.48	0.13	0.11
55	Ц. Цэрэндаваа	0	0.02	0.64	1.15	0.41	0.23	0	0.02	0.64	1.15	0.41	0.23
56	Б. Батжаргал	0	0	0	33.6	10.77	11.65	0	0	0	33.6	10.77	11.65
57	Г. Мөнхбаяр	0	0	0	2.05	1.11	0.52	0	0	0	1.45	0.79	0.37
58	Б. Мөнх-Өлзий	0	0	0	1.25	0.66	0.30	0	0	0	2.80	1.47	0.67
59	Ч. Энхбаяр	0	0	0	1.25	0.66	0.30	0	0	0	1.40	0.74	0.34
60	Б. Ундрал	0	0	0	1.20	0.59	0.28	0	0	0	0.85	0.42	0.19
61	Б. Хулан	0	0	0	0.98	0.48	0.22	0	0	0	0.85	0.42	0.19
62	Лх. Даваажаргал	0	0	0	0.69	0.73	0.19	0	0	0	1.20	1.27	0.32
63	Д. Энхзаяа	0	0	0	0.80	0.53	0.18	0	0	0	0.80	0.53	0.18
64	Д. Цэндсүрэн	0	0	0	0.28	0.27	0.11	0	0	0	0.40	0.38	0.15
65	Н. Батнасан	0	0	0	0.28	0.27	0.11	0	0	0	0.32	0.30	0.12

$WoS$ ,  $Scopus$ -ийн оноогоорх чансаа. Эрэмбэлэхдээ  $AIS_{\sqrt{n}}$ -ийг баримталж, тэнцсэн тохиолдолд  $CiteScore_{\sqrt{n}}$ -ийг, тэр нь тэнцвэл МУИС-ийн жинг ашиглав. Харагдацыг сайжруулахын тулд  $EFS$ -ийг 100-аар үржүүлэв.

болохыг харуулж байна.

4-р баганад тухайн нэгжид харгалзах *WoS*, *Scopus*-ын бүтээлтэй эрдэмтдийн тоог харуулж байна. Эндээс эдийн засгийн шинжлэх ухааны хүртээмж, боловсон хүчний хуваарилалт зохистой бус байгааг харж болно. Тухайлбал *WoS*-д өгүүлэлтэй 27 хүн гадаадад ажиллаж байгаагаас 74% нь их сургуулиудад нь багшилж байгаа ч энэ нь монгол оюутнуудад хүртээмжгүй байна<sup>31</sup>. Монголд буй тийм 37 эрдэмтний 48.6% нь л залуу үед шинжлэх ухаан, технологи дамжуулах үйл ажиллагаанд бүтэн цагаар ажиллаж байна. БШУЯ-аас эдийн засгийн бакалавр болон түүнээс дээш зэрэг олгох эрх авсан боловсролын 34 байгууллагаас ердөө төрийн өмчийн 3 буюу 8.8% нь л олон улсын жишгээрх үнэлгээнд хамрагдах боломжтой байна. УИХ-ийн “Азийн топ-100” болох тогтоолтой илүү холбоотой төрийн өмчийн их сургуулиудын багш нарын ажлын ачааллын бараг 1/3 нь эрдэм шинжилгээний ажилд зориулагдаж байгаа энэ үед 14 их сургууль, 7 дээд сургуулиас 3 нь л *WoS*, *Scopus*-ын өгүүлэлтэй байгаа нь “эрдэм шинжилгээний ажлын” тодорхойлолт нь олон улсын жишгээс хэт гажсан, иймдээ ч энэ шинжлэх ухаан Монголд дэлгэрч чадахгүй байгаагийн бас нэг нотолгоо биз ээ<sup>32</sup>.

Гадаадад буй 28 эрдэмтэн монголчуудын нийт оноонуудын 60%-74%-ийг тус бүр бүрдүүлж байгаа нь дэлхийд үнэлэгддэг тархины гадагшлах урсгал туйлдаа хүрч, эдийн засагчдын өрөмний маань дийлэнх хэсэг нь гадаадад гарсныг илтгэнэ. Хэдийгээр МУИС ерөнхий жагсаалтаар 2-т эрэмбэлэгдэж байгаа ч тэдэнтэй харьцуулшгүй бага үзүүлэлттэй байна. *WoS*-ийн бүтээлтэй 6 эрдэмтэн нь Хүснэгт 6-д харсанчлан эдийн засгийн боловсрол олгож буй үндсэн 2 нэгжид нь бүгд харъяалагддаггүй, 4 нэгжид тархан байрласан, нийлээд ч нийт багш нарынх нь 13%-ийг бүрдүүлэхгүй байгаа нь тэнхимийн харъяалал, үнэлгээндээ шинжлэх ухааны салбарын харъяаллыг бодолцохгүй байгаагийн нэг илрэл юм.

## 6 Бодлогын зөвлөмж

Гадны татах, дотоодын түлхэх хүчин зүйлсүүдийн улмаас *WoS*, *Scopus*-ын бүтээлтэй эдийн засагчид Монголд багшлахгүй байгаа бөгөөд шалтгаан нь цалингийн зөрүү, урамшууллаас эхэлнэ. Хүснэгт 6-д харсанчлан, Монгол эрдэмтдийг төвлөрүүлж буй Хойд Америкийн их сургуулиудын гарааны жилийн цалин дунджаар 95940, жинхэлсэн профессорынх 172150 ам. доллар байдаг (Inomics, 2018). МУИС-ийн жинхэлсэн дэд профессорынх 34.3 сая төгрөг буюу 12007 ам. доллар байгаа нь ижил түвшинд өрсөлдөх судалгаа хийж, магадгүй их хичээл заасныхаа төлөө 8-14 дахин бага цалин авна гэсэн үг юм.

Иймд гадаадад ажиллаж буй эдийн засгийн шинжлэх ухааны эрдэмтдийн бүтээмж олон улсын хэмжээнд хүрсэн байгаа энэ үед өндөр мэргэжилтэй боловсон хүчинг гадаадад төсвөөс болон гадны зээл, тусламжийн санхүүжилтээр бэлтгэх стратегитайгаа зэрэгцүүлэн, тэднийг эргүүлэн татах, дотоодынхоо чадавхыг бэхжүүлэх, хамтын ажиллагааг нь дэмжих арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж эхлэх хэрэгтэй байна. Нээлттэй нийгэм хүрээлэнгээс (*OSI*) хуучин социалист байсан улсуудад зориулан нийгэм, хүмүүнлэгийн ухааны ямар нэг салбараар өндөр хөгжилтэй улсуудад судалгааны зэрэг хүртсэн судлаачид эх орондоо эргэн ирж багшлах хүсэлтэй бол жилийн 4-5 мянган еврогийн мөнгөн

<sup>31</sup> Далхаусын их сургуулийн багш Т.Норовсамбуу СЭЗИС-тай бакалаврын солилцооны хөтөлбөр зохион байгуулж байгаа ч хамрагдалтын статистик тодорхойгүй, Конкордиагийн их сургуулийн багш Д.Лхагвасүрэн 3 монгол докторын оюутан татан аваад байна.

<sup>32</sup> МУИС (2014)-ийн журмаар МУИС-ийн нийт багш нар жилд 26 кредитийн ажил хийх ёстой бөгөөд профессорын албан тушаалд байгаа бол үүний 38.5% нь, багшийн албан тушаалд байгаа бол үүний тал нь эрдэм шинжилгээний ажил байх ёстой. Бусад төрийн өмчийн их сургуулиудын ажлын ачаалал үүнтэй төстэй байх гэж үзэв.

Хүснэгт 8. Эдийн засгийн салбараарх нэгжүүдийн судалгааны чансаа, хүртээмж

#	Нэгж	Оюутан			Эрдэмтэн		Бүтээл		Оноо					
		бак.	маг.	док.	WoSScor.		WoSScor.		AIS	EF	S	IF	C.S.	SNIPSJR
1	Гадаадад буй монголчууд	-	0	3	27	26	77	91	74.9	50.3	90.8	204.1	101.4	119.1
2	МУИС	16200	3625	1035	6	9	14	19	8.34	7.77	17.01	32.94	14.28	13.67
3	Гэрэгэ партнерс ХХК	0	0	0	1	1	6	6	7.54	2.53	9.05	18.95	11.04	9.66
4	Монголбанк	0	0	0	3	7	5	15	3.09	1.30	5.23	20.72	11.07	7.04
5	ХААИС	4211	3262	642	5	4	5	4	1.63	1.75	5.95	7.93	2.79	1.97
6	Монхорус ХХК	0	0	0	1	0	2	0	1.49	5.55	6.48	0	0	0
7	Удирдлагын академи	0	458	59	1	1	1	3	0.88	0.59	1.18	3.23	1.95	1.50
8	Саруул хөдөө ТББ	0	0	0	1	1	1	1	0.73	1.24	1.93	3.55	1.44	1.11
9	Нутаг партнерс ХХК	0	0	0	1	1	1	1	0.73	1.24	1.93	3.55	1.44	1.11
10	Нүүдлийн бэлчээр судлалын төв	0	0	0	1	1	1	1	0.73	1.24	1.93	3.55	1.44	1.11
11	Эрүүл мэндийн яам	0	0	0	2	2	2	2	0.66	0.18	1.38	2.95	0.85	1.12
12	Шинжлэх ухааны академи	0	0	0	1	1	2	2	0.53	2.86	1.81	2.80	1.30	0.75
13	Ветемнет ХХК	0	0	0	1	0	1	0	0.46	0.32	0.92	0	0	0
14	Нээлттэй нийгэм хүрээлэн	0	0	0	1	1	3	3	0.41	0.29	2.32	3.80	1.90	1.09
15	Эдийн засгийн хүрээлэн (ERI)	0	0	0	1	1	1	1	0.34	0.08	0.83	1.27	0.51	0.45
16	Анагаах ухааны хүрээлэн	0	0	0	1	1	1	1	0.33	0.09	0.69	1.47	0.42	0.56
17	Хаан банк	0	0	0	1	1	1	1	0.15	0.27	0.53	0.92	0.50	0.26
18	Инвест Монголиа	0	0	0	1	1	1	1	0.02	0.00	0.44	0.42	0.12	0.10
19	Сангийн яам	0	0	0	0	1	0	1	0	0	0	0.69	0.73	0.19
20	Гаалийн ерөнхий газар	0	0	0	0	1	0	1	0	0	0	0.28	0.27	0.11
21	Анагаахын шинжлэх ухааны УИС	8505	987	163	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Билиг дээд сургууль	404	149	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Газарчин дээд сургууль	666	427	16	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Далайван дээд сургууль	59	14	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Дотоод хэргийн их сургууль	2318	201	243	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Их засаг олон улсын их сургууль	4628	140	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Мандах их сургууль	1924	63	16	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Маргад дээд сургууль	389	249	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Монгол Улсын боловсролын их сургууль	11590	1386	169	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Монголын үндэсний их сургууль	7682	980	70	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Олон улс судлалын дээд сургууль	150	30	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Олон улсын Улаанбаатарын их сургууль	1405	246	27	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Олон улсын эдийн засаг, бизнесийн Д.С.	431	38	3	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Орхон их сургууль	675	686	47	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Отгонтэнгэр их сургууль	1110	123	25	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Сан их сургууль	305	54	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Санхүү эдийн засгийн их сургууль	3744	1861	78	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Соёл эрдэм дээд сургууль	402	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Түшээ дээд сургууль	162	49	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Улаанбаатар эрдэм их сургууль	1738	478	62	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Улаанбаатарын их сургууль	331	143	100	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Үндэсний батлан хамгаалахын И.С.	2211	279	163	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Хөдөлмөр, нийгмийн харилцааны Д.С.	258	95	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Худалдаа үйлдвэрлэлийн их сургууль	470	118	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Хүмүүнлэгийн ухааны их сургууль	3803	345	31	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Чингис хаан дээд сургууль	-	-	-	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Шинэ иргэншил дээд сургууль	5	143	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	ШУТИС	13548	2300	137	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Эдийн засгийн үндэсний дээд сургууль	312	155	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Эко-Ази дээд сургууль	227	66	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
21	Этүгэн их сургууль	5315	174	4	0	0	0	0	0	0	0	0	0	0
	Дүн	95178	19324	3093	56	60	125	148	102.9	67.2	150.4	279.5	142.7	149.2
	Гадаадад буй монголчуудын хувь	-	0	0	48.2	42.6	61.6	59.1	72.8	67.0	60.4	65.2	66.1	74.0

1-р баганад эдийн засгийн хөтөлбөртэй Монголын их, дээд сургуулиуд, *WoS*, *Scopus*-ын өгүүлэлтэй ажиллантай байгууллагууд, мөн гадаадад ажиллаж буй тийм эрдэмтдийг нэгтгэн,  $AIS_{\sqrt{n}}$ -д тулгуурлан чансааг нь гаргав. 3-5-р баганад нь мэдээлэл нь нээлттэй бакалавр, магистр, докторын түвшний оюутны тоог нь тайлагнав (БШУЯ (2020)-аас мэдээлэл нь олдоогүй бол “-” гэж тэмдэглэв). 6-р баганад *WoS* болон *Scopus*-д өгүүлэлтэй эрдэмтдийн тоог харуулж байна. Үлдсэн багануудад  $\sqrt{n}$  жинтэй оноонуудыг нь тайлагнав ( $C.S. = CiteScore$ ).

тэтгэлэг, гадны эрдэм шинжилгээний хурал зөвлөгөөнд илтгэгчээр оролцох нэг удаагийн зардлыг бүрэн даах нөхцөл бүхий 5 жил хүртэлх хугацаатай хөтөлбөрийг БШУЯ судлан хэрэгжүүлбэл өртөг, үр өгөөжийн хувьд ч, хүртээмжийн хувьд ч одоогийн нэг чиглэлт стратегиас илүү үр ашигтай байхаар байна<sup>33</sup>.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үеийн, зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн хуулийг үгүйсгэсэн цалингийн тогтолцоо нь дотооддоо ч хувийн секторынхонтой өрсөлдөх чадваргүй болгож дэлхийн түвшинд хүрсэн эдийн засагчид академик карьераа хаяхад хүргэж байна. Өндөр хөгжилтэй улсуудын хувьд оюутан хичээлийг нь их сонгон үздэг эрэлттэй, бусад салбарынхаас илүү ачаалалтай багш нарт хөдөлмөрийн зах зээлийн онцлогоос хамаарсан нэмэгдэл буюу “market supplement” өгдөг. 2020 оны 2-р улирлын байдлаар санхүү болон даатгалын салбарын дундаж цалин 1.533, боловсролынх 1.043 сая төгрөг буюу 47%-ийн зөрүү байна. МУИС-ийн нэгэн захирлын хэлснээр Монгол хэлний мэргэжлийн карьерийн оргил нь МУИС-ийн багш, харин эдийн засагчдын хувьд энэ нь өөр, жишээ нь санхүү, даатгалын салбар байж болох бол цалинг нь тэгшитгэснээр зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн хуулиар эдийн засгийн сайн багш байх боломжийг боомилж байна гэсэн үг юм. Иймд зах зээлийн нэмэгдэл цалинг нэвтрүүлэх нь зүйтэй байна.

Нөгөө талаар цалингийн шатлалын нягтрал ихтэй нь эрдэм шинжилгээний ажил хийж дэд профессор, профессорын зэрэглэлд дэвшин ажиллах хүсэл эрмэлзлэл, сонирхлыг үгүй хийж байна. Жишээ нь дээр дурдагдсан Хойд Америкийн цалингуудаас дээд, доод зэрэглэлийн цалингийн зөрүү нь 79.4% байна. Харин багш нарынх нь жилийн дундаж цалин нь 8600 ам. доллар байдаг Хятад “Бүтээлээ нийтлүүл, эсвэл ядуур” бодлогынхоо хүрээнд дэлхийн эрдэм шинжилгээний тэргүүлэх сэтгүүлд нэгдүгээр зохиогчоор бүтээлээ хэвлүүлсэн их сургуулийн багш нарыг 160000 хүртэлх ам. доллараар шагнадаг болсноор тийм болон ердийн багш нарын цалинг 1700%-аар ялгаатай байх боломжийг бүрдүүлж байна (Qian, Chen, Shu, 2017). Монгол улсын хувьд ийм судалгаа байхгүй, МУИС (2014)-ынхаар профессор болон ердийн багшийн цалингийн зөрүү нь 35%, мөн *WoS*, *Scopus*-ын бүтээл гаргасан эсэх нь профессор, дэд профессорын зэрэглэл, цол, цалинг тодорхойлох үндсэн хүчин зүйл болдоггүй нь, *WoS*, *Scopus*-ын ач холбогдлыг ойлгодоггүй, сэтгүүлд нь нийтлүүлж үзээгүй хүмүүсээр захиргааны дээд албан тушаалуудыг хашуулж ирсэн нь МУИС-ийн хөгжлийг гацааж буй маш том хүчин зүйл юм.

Уг жагсаалтад хувийн өмчийн их, дээд сургууль огт байхгүй байгаа нь ашиг сонирхол нь шинжлэх ухаанаас хэт тасарсны нэг баталгаа мэт. Уул нь улсынхыг бодвол захиргааны болон санхүүгийн хувьд илүү эрх мэдэлтэй, дээд дарга нарын захиалгаар “шүхрээр бууж ирдэг” профессоруудаас харьцангуй хараат бус, шударгаар томилох боломжтой хувийн сургуулиуд өндөр түвшний судлаачдыг татаж, дэмжих боломжтой байдаг. Иймдээ ч Харвард, Йел, Принстон, МИТ, Ёнсей, Корей, РЭШ, Коч, Сабанчи, Билкент гэх хувийн сургуулиуд улсынхаа чансааны жагсаалтыг тэргүүлдэг (Cokgezen, 2019). Эдийн засгийн салбараар сургалт явуулдаг, ялангуяа магистр, докторын хөтөлбөртэй хувийн их, дээд сургуулиудын профессор, дэд профессор БШУЯ-аас шууд шаардлага тавих хууль, эрхзүйн үндэслэл байдаггүй юм аа гэхэд хөтөлбөрийнх нь боловсон хүчний хувьд дор хаяж нэг *WoS*, *Scopus*-ын өгүүлэлтэй багштай байх ёстой гэсэн шаардлагыг тавьбал энэхүү олон улсын жишиг рүү нь түлхэх нэг алхам болно.

Ийм шаардлагууд тавигдвал тэдгээрийг хангах дотоод бололцоо асар их байгааг уг хүснэгтээс мөн харж болно. Тухайлбал дээр дурдсанаар *WoS*, *Scopus*-ын өгүүлэлтэй

<sup>33</sup> Энэхүү хөтөлбөрөөр зохиогч анх Монголд эргэн ирж 4 жилийн турш хамрагдсан болно. Энэ хугацаанд Монголоос МУИС-ийн Эдийн засаг, Антрологи, Түүх, Анагаахын шинжлэх ухааны УИС-ийн Нийгмийн бодлогын тэнхимүүд уг хөтөлбөрт хамрагдаж байсан.

64 монголын 27 нь гадны улсын төлөө ажиллаж байна. Хангалттай уян хатан нөхцөл, ажлын байр санал болговол эдгээрээс бүр болон түр буцаж ирэх, давхар харъяалалтай ажиллах хүн байх биз ээ. Монголд ажиллаж буй 37-оос 51.4% нь боловсролын салбараас гадна байгаа бөгөөд мөн л зохих нөхцөл, орчин бүрдсэн үед монгол залууст шинжлэх ухааны дэлхийн түвшний мэдлэг, технологи дамжуулах чадавх бүхий, ашиглагдаагүй нөөц бололцоо юм.

## 7 Дүгнэлт

Орчин үеийн эдийн засгийн шинжлэх ухааныг Монголд нэвтрүүлэх, боловсролын тогтолцоондоо тусгах, цаашилбал эдийн засгийн бодлогоо бие даан боловсруулж, хэрэгжүүлэх институцийн чадавхыг сайжруулах нь бидний хувьд нэн тулгамдаад байгаа асуудлуудын нэг юм.

Иймд эдийн засагчид болон байгууллагуудын судалгааны чансааг олон улсад хэрэглэгддэг арга зүйн дагуу гаргав. Ингэхдээ боловсролын болон шинжлэх ухааны гэсэн 2 эдийн засгийн докторын зэрэгтэй 50, эхнийх нь эдийн засгийн бус, харин 2 дахь нь эдийн засгийн шинжлэх ухааны доктор гэсэн 4, эхний докторын зэргийг алгасаж шууд шинжлэх ухааны докторын зэрэг хүртсэн 1, монголын боловсролын доктор хүртсэний дараа барууны доктор нэмж хүртсэн 1 хүн, угаасаа 1 докторын зэрэгтэй 474 хүн, докторын зэрэггүй ч *WoS*, *Scopus*-ын эдийн засгийн сэтгүүлд бүтээлээ нийтлүүлсэн 30 хүн, эдийн засгийн дээд боловсролын байгууллага, нэгжид ажиллаж буй, цахим хуудсанд нь бүртгэлтэй бусад 179 багш, *RePec*-т мэргэжлийн эдийн засагч гэж бүртгүүлсэн бусад 11 хүн, нийт 751 эдийн засагч, БШУЯ-аас эдийн засгийн бакалавр болон түүнээс дээш зэрэг олгох зөвшөөрөл олгосон 34 их, дээд сургууль, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудыг хамруулж, хуучин социалист байсан болон монголчуудын эдийн засгийн докторын зэргээ хүртдэг улсуудынхтай харьцууллаа.

Монгол улсын түүхэнд (давхардуулалгүйгээр) эдийн засгийн топ-5 сэтгүүлд 1, топ-8-д 3, топ-35-д 15, *WoS*-д 40, *Scopus*-д 9 монгол хүн бүтээлээ нийтлүүлжээ. *WoS*, *Scopus*-ын сэтгүүлд бүтээлээ нийтлүүлсэн 65 эдийн засагч нь судалгаанд хамрагдсан 751 хүний нэн бага буюу 8.6% -ийг бүрдүүлж байна. Эдийн засгийн 530 докторын хувьд ердөө 6.6% л тийм бүтээлтэй байгаа нь удиртгалд дурдсан урд хөршийн шинэ стандартаар зэргийнх нь 93%-аас дээш нь хүчингүй гэсэн үг юм. ЗХУ болон ОХУ-ын докторын дээд зэрэг болох *Доктор экономических наук (ДЭН)*-тай 37 хүнээс ганц нь ч, эдийн засгийн профессор цолтонгууд, Монголын дээд зэрэг болох шинжлэх ухааны доктор (*ScD*) 18 хүн, эдийн засгийн салбараарх Монгол Улсын ШУА-ийн 7 академичаас ганцаас бусад нь, мэдээлэл нь нийтэл ил 23 профессороос 2-оос бусад нь, 41 дэд профессороос 4-аас бусад нь мөн тийм бүтээлгүй байна.

Гадаадад буй 28 эрдэмтэн монголчуудын нийт олон улсын хэмжээний бүтээлийн 70 орчим хувийг гаргаж байгаа нь дэлхийд үнэлэгддэг тархины гадагшлах урсгал даамжирч, эдийн засагчдын өрөмний маань дийлэнх хэсэг нь Монголын нийгэм-эдийн засгийн харилцаанд идэвхитэй оролцохгүй байгааг илтгэж байна. Монгол Улсаар овоглосон их сургуульд буй тийм эрдэмтэд нь нийт багш нарынх нь 13%-ийг ч бүрдүүлэхгүй байгаа нь шинжлэх ухаантайгаа холбоогүй байгаагийн нотолгоо юм. Иймд эдийн засгийн доктор, докторын удирдагч, доктор хамгаалуулах зөвлөлийн гишүүн, профессор, дэд профессорын цол, зэрэглэлийг олон улсын жишигт ойртуулан нэгтгэж, тэдний болон академичийн ажлын байрны тодорхойлолтод нь *WoS*, *Scopus*-ын оноо бүхий дор хаяж нэг өгүүлэлтэй байхыг шаардаж, шаардлага хангаагүйг нь зогсоон, цуцлахгүй л бол орчин үеийн шинжлэх



ухааныг Монголд нэвтрүүлэхгүй байх ашиг сонирхлын зөрчилтэй томоохон лобби бүлэг давамгайлж, цаашид ч Монголын нийгмийг шинжлэх ухаантай холбох эрдэмтдийн орон зай үүсэхгүй.

